

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл


2013. 06 сар. №11 (045)

www.mongolianeconomy.mn

Олон соёлын уулзах
цэгийг ол

“Чингис бонд”-ын
ээрэг ба сөрөг тал

ТӨСЛИЙН НЭГ ХЭЛ, НЭГДСЭН СТАНДАРТ






ИЛЧ ГАЗ



**АЯЛАЛ ЗУГААЛГА
АМРАЛТ ЗУСЛАН
АХУЙН БҮХ
ХЭРЭГЦЭЭНД**



**5 ЛИТРИЙН
БАГТААМЖТАЙ
18-20 ЦАГ
ТАСРАЛТГҮЙ АСАХ
ХУЧИН ЧАДАЛТАЙ**

**ДАХИН ДАХИН
ЦЭНЭГЛЭЖ АШИГЛАХ
ЗОРИУЛАЛТТАЙ**



**ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР
АЮУЛГҮЙ
АВСААРХАН**



**МОНГОЛД АНХ УДАА
"ИХ ХАРАНГА" КОМПАНИЙ
ЗАХИАЛГААР ТҮРК УЛСАД
ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
"ИЛЧГАЗ"
"ГОРГАЗ"
КОМПАНИЙ
БОРЛУУЛАЛТЫН 7-Н
ЦЭГЭЭС ХУДАЛДАН АВААРАЙ**



ИХ ХАРАНГА
ЕВРОП ЧАНАРЫН БАТАЛГАА
CE
UTAC: 91116587.

Хаяг:
ИХ ХАРАНГА ХХК оффис
Энхтайвны өргөн чөлөө 18/1
Баянгол дүүрэг 5-р хороо
Монгол улс, Улаанбаатар хот

Вэб хаяг:
www.ikharanga.mn
Утас:
(976)-11-680438; 91116587
Факс:
(976)-11-680437
И-мэйл:
ilchgaz@kharanga.mn

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав /9409-2904/

Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

СЭТГҮҮЛЧ:

Н.Оюунсүвд

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

MONGOLIAN ECONOMY

II улирлын нэмэлт захиалга

Редакцид захиалбал
үнэгүй хүргэнэ

www.mongolianeconomy.mn

Төслийн “Монгол гэр” барья

9



14

Зар сурталчилгааны ирээдүй

Тулхтай хөгжил, чанартай амьдрал

14



“Чингис бонд”-ын зерэг ба сөрөг тал

22

БИЗНЕС

- 8 Төслийн нэг хэл, нэгдсэн стандарт
- 9 Төслийн “Монгол гэр” барья
- 12 Оюутолгойн өв
- 14 Тулхтай хөгжил, чанартай амьдрал
- 16 Олон соёлын уулзах цэгийг ол
- 18 Шилдэг төслийн нууц
- 20 “Чингис бонд”-ын зерэг ба сөрөг тал
- 23 “Чингис бонд”-оос санхүүжүүлэх төслүүд
- 25 Зар сурталчилгааны ирээдүй
- 28 Зөв хандлага ур чадвараас чухал

ЭДИЙН ЗАСАГ

- 30 Монгол Улсын хөгжлийн загвар

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

- 32 Бохирдуулагчдыг магтан дуулахаа болих цаг ирсэн

УУЛ УУРХАЙ

- 34 “Алтайн хүдэр”-ийн “супер” төлөвлөгөө
- 38 Сэтгэл хангалуун амьдрал

МОНГОЛД



Монголын занарын холбоо, “Жени Ойл Шейл Монголиа” компани Занарын тос боловсруулах технологийг судалжээ. Шатдаг занарын судалгаа 1940-1950 онд хийгдсэн бөгөөд түүнээс хойш хийсэн 50 гаруй жилийн судалгааны дүнд Монголын нутаг дэвсгэр дэх шатдаг

занарын мэдээллийг нэгтгэн, мужлалын бүдүүвч боловсруулжээ. Мөн хэтийн төлөвийг үнэлсэн байна. Манай улсад шатдаг занарын есөн сав газар, гурван орд, хэд хэдэн илрэлийн нөөц 788 тэрбум тонн гэж тооцоолжээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийн түвшинг зургаан хувьтай байлгах бодлогыг ирэх онд



хэрэгжүүлэхээр тусгасан байна. Мөн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжиж, барилгын материалын импортыг бууруулж, дотооддоо үйлдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас гаргасан судалгаанд энэ онд эдийн засаг 16 хувиар өсөх аж. 2014-2016 онд зэс, алтны ордуудын үйлдвэрлэл ихээхэн нэмэгдэх бөгөөд газрын тос, төмрийн хүдрийн олборлолт өсөх хандлагатай байгаа нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө гэжээ. Эдийн засгийн өсөлт ирэх онд 14.7, 2015 онд 11.8 хувь байхаар тус тус тооцжээ. Мөн уул уурхайн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүдийн үр дүнд экспорт энэ онд 45 хувиар өсөх таамаг дэвшүүлсэн байна.



Манай улсын гадаад худалдааны бараа эргэлт 2014-2016 онд жилд дунджаар 17.2 хувиар өсч, 2016 он гэхэд 21.7 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа аж. Энэхүү өсөлтөд уул уурхайн салбарын

олборлолт, бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил нөлөөлнө гэжээ. Мөн нийт импортын хэмжээ 2014-2016 онд жилд дунджаар 12 хувиар өсөх аж. Экспортын хэмжээ өссөнөөр гадаад худалдааны тэнцэл мөн хугацаанд дунджаар нэг тэрбум орчим ам.долларын ашигтай байх төлөвтэй байгааг Сангийн яамнаас мэдээллээ.

ХБНГУ-д 2015 оны гуравдугаар сард болон “Ай Ти Би Берлин-2015” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд



Монгол Улс түнш орноор оролцохоор боллоо. Манай улсын хувьд олон улсын хэмжээний уг үзэсгэлэнд анх удаа түншээр оролцох бөгөөд Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний хороо байгуулжээ.

Манай Хөгжлийн банкны үйл ажиллагаа тогтворжсонтой холбогдуулан тус банк болон БНСУ-ын Хөгжлийн банк хооронд байгуулсан удирдлагын гэрээг Засгийн газраас дуусгавар болголоо. Мөн Удирдлагын багуудын хооронд байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулжээ. Харин Монгол Улсын Хөгжлийн банк БНСУ-ын Хөгжлийн банктэй зөвлөх гэрээ байгуулах зөвшөөрлийг олгосон байна.

Дэлхийн орнуудын эдийн засгийн мэдээлэл (2013 оны эхний улирлаар)

	ДНБ /хувиар/	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл /хувиар/	Хэрэглээний үнийн индекс /хувиар/	Ажилгүйдлийн төвшин /хувиар/
АНУ	+1.8	+3.5	+1.5	7.5
БНХАУ	+7.7	+8.9	+2.4	4.1
Япон	+0.5	-7.3	-0.9	4.1
Их Британи	+0.6	-2.2	+2.8	7.9
Канад	+1.1	+2.3	+1.0	7.2
Австри	+0.7	+1.4	+2.3	4.7
Бельги	-0.4	-4.7	+1.0	8.2
Франц	-0.3	-2.5	+1.0	11.0
Герман	+0.4	-2.6	+1.2	6.9
Грек	-5.7	-3.9	-0.2	27.2
Итали	-2.8	-3.8	+1.2	11.5
Нидерланд	-1.2	-5.3	+2.6	8.1
Испани	-2.0	-8.5	+2.4	26.7
ОХУ	+2.1	+2.4	+7.2	5.7
Швед	+1.5	0	0	8.8
Швейцарь	+1.4	+1.7	-0.6	3.1
Турк	+1.4	+0.2	+6.1	10.1
Австрали	+3.1	+4.8	+2.5	5.5
Хонконг	+2.5	+1.3	+3.6	3.5
Энэтхэг	+4.5	+0.6	+10.4	9.9
Сингапур	-0.6	-4.1	+3.5	1.9
БНСУ	+1.5	-3.0	+1.2	3.5
Тайвань	+1.5	-3.3	+1.0	4.2
Бразил	+1.4	-3.3	+6.5	5.7
Өмнөд Африк	+2.5	-3.1	+5.9	25.2

Эх сурвалж: “The Economist”

ДЭЛХИЙ ДАХИНД



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааших эрсдэлтэй тулгараад байна. Гадаад орнуудын эрэлт, хэрэгцээ тааруухан байгаа бөгөөд энэхүү алдагдлыг дотоодын эрэлт, хэрэгцээгээр нөхөх боломжгүй аж. Энэ улиралд тус улсын эдийн засгийн өсөлт 7.7-оос 7.5 хувь болж буурах вий гэж зовниж байна. Үүнийг төрийн эрх баригчид солигдсонтой холбоотой гэж үзэх хандлага ч гарах болжээ.

ОХУ-ын иргэд эдийн засгийн сэргэлтэд итгэл алдрах болжээ. Энэ оны эхний улиралд тус улсын эдийн засаг 1.6 хувь болтол буурсан нь 2009 оноос хойших хамгийн таагүй үзүүлэлт юм. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байгааг Засгийн газрын гишүүд сайтар ойлгож байгаа ч юуны түрүүнд эдийн засаг нь нефть, хийнээс хамааралтай байгааг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

Евро бүсийн эдийн засгийн хямрал нэг жил хагасын туршид үргэлжилж байна. Харин энэхүү хямралын



нөлөөлөл Швейцарийн эдийн засагт мэдрэгдээгүй аж. "Bloomberg" мэдээллийн агентлагаас гаргасан судалгаагаар тус улсын ДНБ өнгөрсөн гурван сараас 0.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй бөгөөд эдийн засгийн өсөлт нь удааших шинж тэмдэг ажиглагдаагүй гэжээ. Дэлхийн санхүүгийн томоохон төв болох Швейцарь эдийн засгийн төрөлжилт, өндөр хөгжлийг хадгалсаар ирсэн орон юм.

АНУ-ын худалдааны алдагдал өнгөрсөн онтой харьцуулахад одоогийн байдлаар ДНБ-ий гурван



хувиас давсан үзүүлэлттэй байна. Тус улс аж үйлдвэрийн салбараа доод түвшинд хүртэл бууруулж, тохирох хэмжээнээсээ хэтэрсэн аутсорсинг хийх болсон. Гэвч хувьцааны үнэ өсөх хандлагатай байгаад ихээхэн найдвар тавьсан хэвээр байгаа аж. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас хойш S&P 500 индекс таван хувийн алдагдалтай байсан бол өнөөдөр 22 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Япон улсын эдийн засгийн өсөлт сүүлийн

жилүүдэд тааруухан үзүүлэлттэй байсаар ирсэн. Одоогийн байдлаар ам.долларын эсрэг иенийн ханш 14 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэвч тус улсын Ерөнхий сайд Шинзо Абэ бодлого тодорхойлогчдыг эдийн засгаа сэргээхэд дэмжлэг үзүүлэхийг шаардсан хэвээр бууруулах шинэ бодлого баримталснаар тус улс зөв алхам хийжээ. Үүнийг тус улсын экспортлогч компаниудын ашиг, орлого нэмэгдэж байгаагаас харж болно. ■



А.Амарсайханы булан



ОНЦЛОХ

ТӨСЛИЙН НЭГ ХЭЛ, НЭГДСЭН СТАНДАРТ

И.ЖАРГАЛ

Чингис бонд"-ыг хэрхэн зарцуулах вэ хэмээн төр, засгийн холбогдох байгууллагын ажил хариуцсан түшмэд толгойгоо бараг хагас жил гашилгаж, иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид "Эх орныхоо баялаг, ирээдүй хойч үеэрээ дэнчин тавьж авсан Чингис бондоо зөв л зарцуулаасай билээ" хэмээн болгоомжлол тээсэн. Ашгүй саяхан Засгийн газраас уг бондоор санхүүжүүлэх төслүүдийн нэрс болоод энэ онд ямар төсөлд хэдэн төгрөг зарцуулахаа зарлаж, энэ талын мэдээллийн хомсдолд ороод байсан олон нийтийн оволзсон хүсэлтийг жаахан ч гэсэн биелүүлэв. Чингис бондоор Тавантолгойн цахилгаан станц, Гудамж төсөл, Өвлийн хүлэмж, Оёдол, Ноос, Ноолуур гээд дэд бүтцийн томоохон төслөөс эхлээд өмсөх, идэх хэрэгцээгээ ойрын ирээдүйд импортын биш, дотоодын үйлдвэрлэлээр хангах том зорилтууд дэвшүүлжээ. Гагцхүү одоо Чингис бондоор санхүүжих төслүүдийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ? гэдэг асуудал монголчуудын өмнө тулгарч буй. Өнгөрсөн хугацаанд том, жижиг цөөнгүй төсөл Монголд хэрэгжсэн ч эдийн засгийн өгөөж, улсын хөгжлийг хэр урагшлуулсан бэ гээд харвал тийм ч сайн үзүүлэлт харагдахгүй гэдэгтэй олон хүн санал нийлнэ. Өнгөрсөн сарын 21-нд Засгийн газрын дэмжлэгтэй, Төслийн удирдлагын хөгжлийн хүрээлэнгээс санаачилан Төрийн ордонд болсон "Сайн төсөл амжилтын гараа" анхдугаар чуулганд оролцогчид ч ийн ярьж байсан. Тэгвэл тус чуулган нь Чингис бонд тодотголтой том төслүүд яригдаж буй энэ цаг үед болсноороо нэлээд онцлог, ач холбогдолтой байв. Монголд төслийн нэгдсэн стандарт, арга аргачлал, хэмжигдэхүүний талаар нэгдсэн ойлголт байхгүй явж ирсэн нь ялангуяа төр, засгийн ханд Чингис бондын төслүүдийг үнэлж дүгнэж, сонгон шалгаруулахад ихээхэн тээг болж байсан тухай Ерөнхий сайд Н.Алтанхуяг "Сайн төсөл амжилтын гараа" чуулганы үеэрх нээлтийн үгэндээ хэлэв. Мөн тэрбээр "Төслийг хэрэгжүүлэх, удирдлагаар хангах чиглэлээр манай хувийн хэвшлийнхэн

нэлээд түрүүнд явна. Харин төр, засгийн ханд энэ талын дадлага туршлага бага байна. Тиймээс би энэ чуулганд төр, засгийн байгууллагынхныг түлхүү оролцуулаарай гэсэн байгаа" хэмээн онцолсон.

Өнгөрсөн хугацааны төслүүдээс бидэнд алдсан оносон зүйл багагүй бий. Төслийн удирдлага, менежментийн чадварт суралцаж эхэлж байгаа учраас монголчуудын дунд төсөл гэхээр бөөн мөнгө ороод ирэх мэт, төсөл дээр ажиллаж байгаа хүнийг амархан баяждаг гэсэн өрөөсгөл ойлголт байдаг. Гэхдээ Монголд хэрэгжсэн төслүүдээс АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн 280 гаруй сая ам.долларын төсөл туршлага, мэдлэг өгсөн бол Монголын говьд дэлхийн 44 орны тугийг нэг дор мандуулсан томоохон үйл явдал болсон нь Оюутолгой төслийн үр дүн юм. Одоо ч Монголд Тавантолгой, "Шинэ төмөр" зам гээд дэлхийн хөрөнгө оруулагчид болоод хөршүүдийн арааны шүлсийг асгаруулсан төсөл цөөнгүй бий. Түүнчлэн сүүлийн үед гадаадад төслийн удирдлагын чиглэлээр мэргэжил боловсрол эзэмшсэн монгол залуус олширч, сайн төслүүд хэрэгжүүлж буй монгол менежменттэй компаниуд ч салбар бүрт нэмэгдэж байгаа нь сайшаалтай.

Гагцхүү төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн салбарынхан төслийн нэг хэл, нэгдсэн стандарттай болж, нэг зүгт харах нэгэн зорилгын дор бүтэн өдөр чуулсан хурлын үр дүнг гаргах нь чухал. Энэ ч үүднээс манай "Mongolian Economy" сэтгүүл төслийн анхдугаар чуулганы үеэр яригдсан гол асуудлууд, дотоод, гадаадын мэргэжлийн хүмүүсийн сонирхолтой илтгэл, ярилцлага, Чингис бондоор санхүүжүүлэх төслүүд, Бондын хөрөнгийн үр өгөөжид энэ удаагийн дугаараа хандууллаа. "Сайн төсөл амжилтын гараа" чуулган төслийн удирдлагын чиглэлээр өнөөдрийн олсон амжилтаа улам бататгаж, алдаа дутагдлаа гээж, дэлхийн түвшний өргөө цагаан гэр барихыг зорьж, хурлаас түүнийхээ тулах баганыг босгож чадсан нь сайн хэрэг. ■



АСУУДАЛ

ТӨСЛИЙН “МОНГОЛ ГЭР” БАРЬЯ

Б.ЭНХЦЭЦЭГ

“Төсөл бичүүлнэ, бичнэ, бэлэн төсөл зарах уу, авах уу” гэсэн зар хэвлэлийн хуудаснаа харагдах нь олонтаа. Гадаад дотоодын холыг харж, хөгжлийг далласан олон төсөл өнгөрсөн хугацаанд манайд хэрэгжсэн ч хэд нь чухам товлосон хугацаандаа дуусч, үр дүнд хүрч, өгөөжөө өгснийг хэлэхэд хэцүү. Манай улс ямар стандарттай нь ойлгомжгүй учраас тухайн төсөл санал болгож буй орнуудын стандартаар л ажиллах болдог. Монгол Улс төслийн талаар дэлхийтэй нэг хэлтэй болж, тогтсон

стандарт барьж ажиллах хэрэгтэйг өнөөгийн алдаж онож байгаа туршлага харуулж буй. Үүнийг Оюутолгой, Тавантолгой гэх мэт дэлхийд танигдсан томоохон төслүүд ч гэрчлэх. Тиймээс энэ чиглэлийн дотоод, гадаадын мэргэжилтэн, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагынхан дээрх нэгдсэн зорилгын дор өнгөрсөн сард чууллаа.

Хэрэгжсэн, хэрэгжээгүй төсөл хэмээх олон хуудас цаас монголчуудын хувьд тогтвортой амьдралын багана ►►

► бус бага хүүтэй мөнгө босгох арга байсаар ирснийг хороо, дүүргүүдээс эхлээд төр, хувийн хэвшлийн төслүүдийн гараа, бариа гэрчилнэ. Олонд танигдаж, түмэнд нүдлэгдсэн төслүүд тааруухан сажилж яваа нь ч бий. Жишээ нь, Эрдэнэс-Тавантолгойн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, 100.000 айлын орон сууц, Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, Чөлөөт бүс, Төмөр замын төслүүд тэргүүтэй ар араасаа жагсана. Тэдгээрийн үйл явц, үр дүн нь хойшилсоор, хүлээлгэсээр. Манай улсын хувьд төсөл хэрэгжүүлэхэд хоёр үндсэн асуудал тулгардаг байна. Нэгдүгээрт, баттай мэдээлэл хомс. Хоёрдугаарт, улс төрийн тодорхойгүй байдал. Үүнд, төр солигдох, удирдлага өөрчлөгдөх, гэрээ өөрчлөгдөх буюу хүчингүй болох, хэрэгжилт удаашрах зэрэг хүчин зүйл голлоно. Удирдлагын академийн бизнесийн удирдлагын тэнхимийн профессоруудаас бүрдсэн багийнхан манай улсын 300 гаруй байгууллагад төсөл хэрэгжүүлэх чадамжийн судалгаа хийжээ. Судалгааны дүнд компаниудын төслийн чадамжийн үзүүлэлт 61.5 хувьтай гарсан байна. Мөн Төслийн хөгжлийн удирдлагын хүрээлэнгээс төслийн менежерүүдийн дунд санал асуулга явуулсан бөгөөд үүний дүнд нэгдмэл ойлголтгүй, арга зүйгүй учраас хөгжих хурд саарч, нэг зүгт явж чадахгүй байгаа нь харагдаж байгааг Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэнгийн тэргүүн Ц.Өнөржаргал илтгэлдээ дурдсан юм.

Тал дээр тарсан мал шиг учир замбараагүй одоогийн болоод ирээдүйн төслүүдийг цэгцэлж, тэрхүү хөлс хүч, хөрөнгийг хөгжил болгох нэгдсэн “уургатай” болох цаг нь болж. Өнгөрсөн сарын 21-нд Төрийн ордонд болсон Төслийн удирдлагын анхдугаар чуулганыг нээж Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Төслийн удирдлагын нэг стандарттай болж, дэлхийд нэг зарчим, алсын хараатай урагшлая. Үгүй бол ялангуяа төсвийн мөнгөөр хийж байгаа сургууль, цэцэрлэгийн засварыг нэг нь 600 сая төгрөгөөр нөгөө нь хоёр тэрбум төгрөгөөр хийх жишээтэй. Энэ хурлыг хийснээрээ төсөл нийгмийн хөгжлийг дэмжсэн, эдийн засгийн үр ашигтай байх, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх гэсэн гурван үндсэн шалгуурт тэнцэж байх ёстой” хэмээсэн. Нэгдсэн стандарт, аргачлалгүй учир Чингис бондын мөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулахад хүндрэлтэй байсан гэдгийг Эдийн засаг хөгжлийн яамны мэргэжилтэн С.Санжжав тус чуулганы үеэр хэлж байсан. Нэгдсэн стандарттай болчихвол таван тэрбумын бондын үлдэгдэл орж ирэхэд, төслийн шалгаруулалтад цаг хугацаа, сонгон шалгаруулалтын асуудал үүсэхгүй гэдгийг онцолж байлаа.

Төслийн удирдлага нь зорилтуудаа тодорхойлох, цаг хугацааг үнэлэх, нөөцүүдээ тодорхойлох, санхүүжилтээ бэлтгэх, үйл явцыг хянах, төлөвлөгөөг дахин сайжруулах цогц үйл явц аж. Өөрөөр хэлбэл, төслийн удирдлага нь төслийн менежментийг хэлж байгаа бол төсөл нь оролцогч талуудын сонирхлыг нэгтгэн системчилсэн баримт бичиг гэж болно гэдгийг мэргэжилтнүүд тэмдэглэсэн. Стандартын талаар “Төслийн менежер” сэтгүүлд салбартаа шилдэг туршлагад тооцогдох мэдлэгийн сангийн нэгдмэл ойлголт бөгөөд нийтээр дагах хэв маяг юм” хэмээн тодорхойлжээ. Тэгвэл монголчууд төслийн нийтээр дагаж мөрдөх хэв маягаа олохыг эрмэлзэж, чуулсан хэрэг. Олон улсад АНУ, Япон, Англи, Австрали, Герман зэрэг орны төслийн удирдлагын стандарт тогтоох олон арван санаачилга хэрэгждэг. Үүнд IPMA/ICB3, P2M, Prince2, ISO21500 зэрэг стандарт багтана. /Хүснэгт 1-ээс харьцуулж харна уу/.

Энэ үеэр төр засгийн төлөөлөл, холбогдох эрдэмтэн багш, судлаачдын зүгээс PM-BOOK-ыг онцолж байв. Төслийн удирдлагын хүрээнд тус стандартыг нэвтрүүлж, тодорхой үе шатуудын түвшинд ISO стандартыг нутагшуулж ажиллах юм байна. Мэдлэгт суурилсан тус стандартыг энэ онд шинэчлэн баталсан нь бусдаасаа түрүүнд явааг гэрчилнэ. Дээрх стандарт нь төслийн амьдралын мөчлөгийг эхнээс нь дуустал үргэлжлэх удирдлагын үр дүнтэй аргачлал хэмээдэг байна. Төрөл бүрийн салбарт янз бүрийн төслүүдийг хамран үйл ажиллагаа явуулдаг

АНУ-ын Төслийн удирдлагын хүрээлэнг /PMI/ төлөөлөн ирсэн Колин Мэрфи тус хүрээлэнгээс нийт 13 төслийн стандартыг нэвтрүүлснээс хамгийн амжилттай нь PMBOOK гэдгийг онцолж байлаа. Дэлхийд 50 орчим төслийн удирдлагын аргачлал бий. Тэгвэл PMI байгууллагаас гаргасан нэгдсэн PM-BOOK стандарт нь хэн ч ашиглаж болох энгийн гарын авлага бөгөөд олон улсад нэвтрэх боломж олгодог. Учир нь, өнөөдөр 180 гаруй орны төслийн үндсэн хэл нь PMBOOK болжээ. Өөрөөр хэлбэл, төслийн нэгдсэн стандарттай болсноор дотооддоо төдийгүй олон улсад ойлголтын зөрүүгүй болох нь.

“Сайн төсөл амжилтын гараа” анхдугаар чуулганыг зохион байгуулах санаачилга гаргаж, Засгийн газраар дэмжүүлж чадсан Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэнгийн тэргүүн Ц.Өнөржаргал “PMBOOK стандартыг дээд боловсролын агуулгад оруулж, төслийн сайн менежерүүд гарч ирснээр ISO стандартыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ, төсөл гарч ирэх боломжтой. ISO стандартаар баталгаажсан сайн төсөл хэрэгжүүлэхийн тулд PMBOOK стандартын ►

Хэрэгжсэн, хэрэгжээгүй төсөл хэмээх олон хуудас цаас монголчуудын хувьд тогтвортой амьдралын багана бус бага хүүтэй мөнгө босгох арга байсаар ирснийг хороо, дүүргүүдээс эхлээд төр, хувийн хэвшлийн төслүүдийн гараа, бариа гэрчилнэ.

▶ талаарх мэдлэгийг эзэмших ёстой” гэв. PMBOK нь 600 гаруй хуудас ч мэдлэгт суурилсан төслийн удирдлагын стандарт учир байнга шинэчлэгддэг бөгөөд гарын авлагын хэмжээнд бүрэн ашиглах боломжтой юм байна.

Өнөөдөр төсөл гэдэг үг талхтай адил өргөн хэрэглэгддэг болсон ч үр дүн нь зөвхөн Монголд төдийгүй дэлхий нийтэд хангалттай бус байгааг мэргэжилтнүүд хэлж буй. АНУ-ын Төслийн удирдлагын хүрээлэнгийн 1000 төслийн хүрээнд хийсэн судалгаагаар нийт компанийн 20 хувь нь төслөө төлөвлөлтийн дагуу гүйцэтгэж, үр дүнгээ хүртжээ. Харин үлдсэн нь цаг хугацааны болоод нэгдсэн төлөвлөлт дутуу, хамтын ажиллагаа тааруу, хяналт сул, төсвийн удирдлага дорой байсантай холбон тайлбарлажээ. Өвдөг шороодсон нийт төслийн гүйцэтгэлийг ангилж үзэхэд харилцаа холбоо, хамтын ажиллагаан дээрээ 50 гаруй хувиар алдсан гэдэг үнэлгээ авчээ. Харин сайн төсөл гэж юуг хэлдгийг Америкийн Монгол судлалын төвийн захирал Марк Тассэ “Төлөвлөсөн цаг, мөнгө, зорилгодоо хүрэхийг хэлнэ” хэмээн тодорхойлсон юм.

Нэгдсэн стандарттай болно гэдэг нь аль ч салбарын ямар ч төслийн үндсэн чиг удирдлага ижил байна гэсэн үг аж. Төсөл эхлэлээсээ төгсгөл хүртлээ зөв төлөвлөлттэй байж гэмээнэ амжилт олдог гэдгийг дээрх хурлын илтгэгчид олон удаа онцолсон. АНУ-ын Төслийн удирдлагын хүрээлэн Монгол Улстай хамтарч энэ чиглэлийн жишиг байгууллага байгуулахаар болсон юм. Компаниуд бие даан тус

байгууллагад элсэж, төслийн удирдамж, жишээг ашиглах боломжтой болно.

Төслийн удирдлагын хурлаар хэлэлцсэн асуудлуудыг нэгтгэж зөвлөмж гарган оролцогчдоо хүргүүлэх юм. Улмаар нэгдсэн стандартыг амжилттай өлгийдэн авч, төслийн нэгдсэн удирдлагыг нутагшуулж, төслийн “монгол гэр” барихын тулд доорх санаачилгуудыг зөвлөмжид багтаахаар болсон билээ.

- Хууль эрх зүйн шинэчлэл
- Төр, хувийн хэвшлийн манлайлал чадамжийг дээшлүүлэх
- Боловсролын салбарын хөтөлбөрийн өөрчлөлт
- Хөтөлбөрийн боловсруулалт ба хэрэгжүүлэлт
- Стратегийг нэвтрүүлэх
- Үндэсний стратегийн үндсэн чиглэл бий болгох
- Иргэдийн бүтээлч санаачилга
- Бүтээлч санаачилгыг дэмжих тогтолцоо

Манайд төслийн муу, сайн жишээ чамгүй бий. Үр өгөөжийн хувьд ч хүссэн үр дүндээ хүрч чадаж байсан эсэх нь эргэлзээтэй. Тэгвэл энэхүү чуулганаар хэлэлцсэн асуудлуудыг хэрэгжүүлж, нэгдсэн стандартаар ажилладаг болвол төсөл хэрэгжүүлэгчид эрсдэлд бэлэн, мөнгөнд тооцоотой, цагтаа баримжаатай болж, бариандаа магад эрт хүрдэг болох биз. ■

Хүснэгт-1. Олон улсад хэрэглэдэг төслийн стандартуудын харьцуулалт

Төслийн стандартууд	IPMA/ICB3	P2M	PMBOK	PRINCE 2	ISO21500
Үзүүлэлт					
Нэрний тайлбар	International Project Management Association International Competence Baseline 3	Project&Program Management for Enterprise Innovation	Project Management Body of Knowledge	Project Controlled environments	International Organization for Standardization
Анх нэвтрүүлсэн огноо	1965	2001	1987	1989	2006
Сүүлийн шинэчилсэн огноо	2008	2001	2013	2009	2009
Нэвтрүүлэгч байгууллагын нэр	Investments in Education Development /IED/	Project Management Association of Japan /PMAJ/	Project Management Institute /PMI/	Association for Project Management /APM group/	British Standard Institute
Аль улсын стандарт	Олон улс /Европын холбоо/	Япон	АНУ	Европын холбоо / Их Британи/	Олон улс /Их Британи/
Гишүүдийн тоо	150000	100000	700000		
Гишүүн орны тоо	55	40 гаруй	180 орон, 260 салбар	50	31
Төв нь хаана байрладаг	Герман	Япон	Америк	Англи	Их Британи
Хэрэглээний онцлог	Чадамжид суурилсан	Инновацид суурилсан	Мэдлэгийн үндсэн ойлголт	Хяналтад суурилсан	Чанарт суурилсан



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ОЮУТОЛГОЙН ӨВ

“Би бусдаас илүү алсыг харж байсан. Учир нь би аварга биетүүдийн мөрөн дээр зогсож байсан юм”

Исаак Ньютон

Б.БАЯРТОГТОХ

Манай улсад амжилттай хэрэгжиж буй олон төсөл хөтөлбөр бий. Түүнээс Оюутолгой, Монголын мянганы сорилтын сангийн төслийг онцолж байна. Уул уурхайн салбарт төдийгүй дэлхийд “Оюутолгой” хэмээх төслийн нэр дуурсаар анхны баяжмалаа хүлээн авсан. Уг төсөл нь Монгол Улсад эдийн засгийн үр ашиг өгөхөөс гадна хүний хөгжлийн асар үнэтэй капиталын “тоосго” өрж байгаа. Энэ нь дунд болон урт хугацаандаа монгол хүний ур чадвар, оюуны үнэлэмж, нэр хүндийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх баталгаа болж байгаа юм. Түүнчлэн орон нутгийн хөгжил гэлтгүй бүс нутаг, цаашилбал Монгол Улсын ирээдүйн хөгжлийг дардан бүтээх тулгуур багана болохыг төсөл хэрэгжүүлэгч нар онцолж байна. Тус төслийн дэд захирал Т.Мөнхбат “Оюутолгой төсөл нь манай улсын түүхэн дэх хамгийн том, дэлхийн тавцан дээр одоогийн байдлаар мега төслийн хэмжээнд

орж байна. Бид ямар ч дэд бүтэцгүй говь нутагт ердөө 30 орчим сарын хугацаанд уул уурхайн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт зэсийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийг босгож чадлаа” хэмээн онцлон тэмдэглэсэн.

Төслийг тодорхойлох, шийдлийг сонгон шалгаруулах, шалгарсан шийдлийг боловсруулах, шийдлийг гүйцэтгэх, ашиглалт эхлэх. Эдгээр таван үе шатыг “Оюутолгой” төсөл туулжээ. Үүнээс гадна эхний 2-3 шатанд төслийн үр өгөөжийг тодорхойлох бол 3-5 шатанд үр өгөөжийг дүгнэдэг байна.

Оюутолгой төслийн үйлдвэр нь жилд 35 сая тонн, өдөрт 96 мянган тонн хүдрийн баяжмал гаргах хүчин чадалтай. Бүтээн байгуулалтын оргил үед төслийн талбарт 14589 хүн ажилласан бөгөөд үүний 8769 нь монгол ажилчид байжээ. Далд уурхайгаас Оюутолгойн нийт баялгийн 80 хувийг олборлох төсөлд НҮБ-ын 44 орны 18 мянга орчим инженерийн хамтын хүч оролцсон болохыг хөрөнгө оруулагчид тодотгож буй.

Оюутолгой төслийн ерөнхий гүйцэтгэгч “Fluor” компанийн Инженерингийн менежер Д.Мөнхболд “Эхний ээлжинд төслийн цар хүрээг тодорхойлно. Үүнд байгууламж буюу үйлчилгээний гүйцэтгэл ордог. Төсөл гүйцэтгэх ▶



► төлөвлөгөөг аргачлалын хамтаар боловсруулдаг” гэв. Ямар ч ашигтай төсөл байсан эхний ээлжинд төслийн зардлын тооцоог нарийвчлан гаргах шаардлагатай байдаг аж. Мөн төслийн удирдлагын түвшинд төлөвлөгөө гаргахаас гадна эрсдэлийн судалгааг хийж, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулдаг байна. Оюутолгой төслийг цааснаас бодит бүтээн байгуулалт болгон хөгжүүлэхэд 6.2 тэрбум ам.доллар зарцуулсан нь манай улсын энэ оны төсвийн зарлагатай бараг л тэнцэж байгаа юм.

Мөн Засгийн газартай хамтран мэргэжлийн боловсролын салбарт 126 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж эхлээд байгаа нь сайн төслийн тод жишээ болж байгааг Д.Мөнхболд хэллээ. Оюутолгой төслийг бүтээн байгуулсан “Fluor” компани нь АНУ-ын хамгийн том инженеринг ба барилгын компани аж. Өнөө жил 101 жилийн ойгоо тэмдэглэж буй тус компани Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт оролцох хүсэлтээ Эдийн засгийн хөгжлийн яаманд илгээжээ.

“Fluor” нь Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн инженеринг, хангамж, барилга угсралтын менежментийг хийжээ. Тэд баяжуулах фабрик, гүний уурхайн цамхаг, засмал зам, 220 квт шугам, ус дамжуулах хоолой, дулааны станц, нисэх буудал, үйлчилгээний болон оффисын барилга гээд шинэ Оюутолгойг бүтээсэн байна. Дэлхийн хэмжээний төслийн зураг төслийг Ванкувер, Шанхай, Бээжин, Перт, Улаанбаатарт гүйцэтгэсэн аж.

“Бид үйлчлүүлэгчиддээ найдвартай түншийн үлгэр жишээ байхыг эрмэлзэж ирсэн. Үүний тулд бид амласандаа хүрэх үүрэгтэй. Энэ нь өндөр өрсөлдөөнт зах зээлд бусдаас ялгарах чухал үнэт зүйл” хэмээн Мөнхболд онцоллоо. Энэ нь суурьт төвт гүйцэтгэл хэмээх зарчим аж.

Олонх төсөл таван үе шатаас бүрддэг байна. Төслийг тодорхойлох, шийдлийг сонгон шалгаруулах, шалгарсан шийдлийг боловсруулах, шийдлийг гүйцэтгэх, ашиглалт эхлэх. Эдгээр таван үе шатыг “Оюутолгой” төсөл туулжээ. Үүнээс гадна эхний 2-3 шатанд төслийн үр

өгөөжийг тодорхойлох бол 3-5 шатанд үр өгөөжийг дүгнэдэг байна. Тухайн төслийг гүйцэд тодорхойлсон эсэхээс хамаарч гүйцэтгэлийн чанарт А, В гэсэн дүн тавьдаг аж. Хэрэв төслийг дутуу тодорхойлсон бол С, D гэсэн үнэлгээнд шилждэг байна.

Бидний танилцаж буй “Оюутолгой” төслийн баяжуулах үйлдвэрийн барилгын ажилд нийтдээ 19 сая тонн төмөр хийц оржээ. Үндсэн бутлуурын туузан дамжуулга гэхэд нийслэлийн Энхтайваны гүүрээс даруй долоо дахин урт. Төслийн хүрээнд өнгөрсөн хугацаанд дотоодын боловсон хүчнийг хөгжүүлэх, үндэсний гэрээлэгч нарыг тодруулах, хөгжүүлэх зэрэг давхар “төсөл” хэрэгжүүлсэн байна.

“Fluor” компанийн зүгээс Монгол Улс төсөл хэрэгжүүлэхэд боломжтой гэсэн үнэлгээ авчээ. Тухайлбал, төслийн хүрээнд бусад байгууллагатай хамтран ажиллахад нээлттэй. Мөн харьцангуй цөөн хүн амтай боловч өндөр боловсрол бүхий чадвартай боловсон хүчинтэй, байгаль цаг уурын нөхцөл байдал таатай гэжээ. Төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа COMECO компанийн 44 см бетон хучилт дэвсдэг төхөөрөмжийг “Ханбумбат” нисэх буудлын ажилд ашигласан байна. ■

Оюутолгой төслийн өрнөл:

2006: Суурь зураг төсөл

2007: Зураг төсөл түр зогсоо

2008 -2009: Төслийн саатал

2009: Шинэчилсэн суурь зураг төслийн ажил

2010: Барилга угсралтын ажил эхэлсэн

2013: Уурхай бүрэн хүчин чадлаар ажиллана

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

“ТУЛХТАЙ ХӨГЖИЛ, ЧАНАРТАЙ АМЬДРАЛ”



Б.БАЯР

Дээрх уриаг дэвшүүлэн тавьсан Монголын мянганы сорилтын сан зургаан төслийг хэрэгжүүлж байгаа. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилготой монголчуудын боловсруулсан хөтөлбөрийг АНУ-ын Засгийн газар санхүүжүүлсэн нь энэ. Буцалтгүй тусламжийн хүрээнд нийт 285 сая орчим ам.долларын санхүүжилтээр таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх уг хөтөлбөр ирэх есдүгээр сард хаалтаа хийх гэж байна.

Хөрөнгийн эрх, Хот орчмын бэлчээр, Мэргэжлийн боловсрол сургалт, Эрүүл мэнд, Авто зам, Цэвэр агаар сан гэсэн зургаан гол салбарт хөрөнгө оруулалт хийсэн хөтөлбөрийн төсөл сайн засаглалыг Монголд нутагшуулсан хэмээн албаны хүмүүс хэлж байгаа. Эрүүл мэндийн төслийн хувьд харагдах юм бага боловч эдийн засгийн үр өгөөж, үлдэц ихтэй аж. Америкийн мянганы сорилтын корпорациас тус төслийг хэрэгжүүлэхэд нийт 39 сая ам.доллар зарцуулжээ.

Уг төслийн зорилго нь халдварт бус өвчлөл болох зүрх судасны өвчин, чихрийн шижин, умайн хүзүүний болон хөхний хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж оношлох, үр дүнтэй өртөг багатай эмчилгээгээр хангах олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэх байв. Мөн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийн дадал, хандлагыг өөрчлөх, эрүүл амьдрах хэв маягийг хэвшүүлэхэд чиглэсэн боловсрол, мэдээллийн үйл ажиллагаа явуулахад өнгөрсөн хугацаанд анхаарчээ.

Төслийн хүрээнд зүрхний шигдээс, ▶

► цус харвалтыг оношлох, эмчлэх зорилго бүхий ангиографи, компьютер томографын аппаратыг П.Н.Шастины нэрэмжит Улсын III төв эмнэлэгт суурилуулахаар ажиллаж байгаа аж. Тоног төхөөрөмжүүд суурилуулахаас гадна цус харвалт буюу зүрхний шийгдээсийг оношлох, эмчлэх төв байгуулахаар болсон байна. Энэ нь өвчлөлийн оношилгоо, эмчилгээг цогцоор нь хийх боломжоор хангах зорилготой юм байна. Тус тасгийг ирэх есдүгээр сард багтаан хүлээлгэн өгөхөөр төлөвлөжээ.

Төсөл нь хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан албан ёсны гэрээ болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хатуу хяналт шаардлага дор төсөл амжилттай сайн хэрэгжсэн. Ингэснээрээ Монголын эдийн засагт төдийгүй монголчуудад их зүйл үлдээсэн хэмээн төслийн захирал А.Мөнхтайван хэллээ.

Эрүүл мэндийн төсөл нь нэг удаа хэрэгжээд өнгөрөх бус цаашид ч үргэлжлэх алсын хараатай бодлогын үндэс суурь болох аж. Тэдний бий болгосон тогтолцоог манай улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам үргэлжлүүлэн авч явах гэрээ хийсэн байна. Энэ нь төсөл тогтвортой хэрэгжих бололцоог нээсэн. Тиймээс эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ цаашид тогтмол хэрэгжээд явах аж.

Төслийн менежментэд төсөл боловсруулах, батлах, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт удирдлага, хаалт гэсэн зарчим үйлчилжээ. Уг төслийн зохион байгуулалтын бүтэц бүтээгдэхүүнд суурилсан багийн босоо зохион байгуулалт гэсэн багаар ажиллах бүтэц бий болгосон нь төсөл амжилттай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлжээ. Төслийн “ноу хау” нь ажлын төлөвлөгөө байдаг аж. Үүнээс гадна төсөлд учирч болзошгүй эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг давхар боловсруулах шаардлагатай юм байна.

Төслийн хүрээнд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, түүнд шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулахдаа дэд бүтцийг нь шийдэж явдгаараа онцлог бөгөөд өгөөжтэй зүйл юм. Үүнээс гадна хүнсний үйлдвэрлэлийнхэнтэй хамтран, хүн амын эрүүл мэндийг хамгаалж, халдварт бус өвчлөлийг бууруулахад анхаарч ажиллажээ. Тухайлбал, “Талх чихэр” компани

“Атар” талхныхаа давсыг сүүлийн гурван жилд 12-15 хувиар багасгажээ. Мөн “Мон сүү” компани эрүүл мэндэд ээлтэй, тослоггүй сүү үйлдвэрлэж, тарагныхаа элсэн чихрийг бууруулан зохист хэмжээгээр үйлдвэрлэж байна.

“Манай улсад төсөл хэрэгжүүлэхэд баталгаатай мэдээлэл хомс. Эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй ганцхан төсөл байсан. Тиймээс үндсэн суурь болох 10 судалгааг эхний жилдээ хийсэн. Судалгаанаас үүдэж цаг хугацаа алдсан. Улс төрийн тогтворгүй байдал ч нөлөөлж байсан. Уг нь дэлхийн стандарт бүхий төсөл хэрэгжиж байгаа нь

дотоодын байгууллагын чадавхыг сайжруулж, олон улсын түвшинд өрсөлдөх чадварт сайнаар нөлөөлсөн” хэмээн А.Мөнхтайван онцолсон. Тэрбээр манайханд багаар ажиллах чадвар сул, хийж буй ажлыг үгүйсгэх, “Би” гэдэг хандлага газар авч байгаа. Энэ нь төслийн үр бүтээлд сөргөөр нөлөөлдөг” гэж монголчуудынхаа сул талыг ч хэлэв.

Өнгөрсөн хугацаанд Мянганы сорилтын сангийн 227 гэрээг

Монголын байгууллага авсан бөгөөд гэрээний үндсэн дээр 88 сая ам.долларын ажил, үйлчилгээг үзүүлжээ. Мөн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх зэрэг дэд бүтцийн бүх асуудлыг төслийн санхүүжилтээр хангасан байна. Тухайн орны эрэлт хэрэгцээнд тулгуурласан учраас үндэсний хөтөлбөр Засгийн газрын бодлогод нийцсэн болохыг А.Мөнхтайван онцолсон. Харин донор байгууллагын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй. Үүнээс үүдэн ажил давхардах тохиолдол гарч байсан. Төслийн явцад төрийн албан хаагчдын оролцоо хангалтгүй байсан гэлээ.

Эрүүл мэндийн төслийн сайн туршлагыг бусад таван төсөлд ашигласан бол АНУ-ын Мянганы сорилтын корпораци бусад орнуудад хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүддээ нэвтрүүлжээ. Одоогоор 10 гаруй оронд хэрэгжих 50 орчим төсөлд Монгол Улсад нэвтрүүлсэн аргыг хэрэглэж байгаа аж. ■

**Эрүүл мэндийн төсөл
нь нэг удаа хэрэгжээд
өнгөрөх бус цаашид
ч үргэлжлэх алсын
хараатай бодлогын үндэс
суурь болох аж. Тэдний
бий болгосон тогтолцоог
манай улсын Засгийн
газар, Эрүүл мэндийн яам
үргэлжлүүлэн авч явах
гэрээ хийсэн байна.**

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

ОЛОН СОЁЛЫН УУЛЗАХ ЦЭГИЙГ ОЛ



Б.ЭНХЦЭЦЭГ

Америкийн Монгол судлалын төвийн захирал Марк Тассе нь Бизнес хөгжлийн чиглэлээр 15 жил ажилласан бөгөөд Азид дэлхийн бизнесийн хөгжлийн мэргэжилтнээр зургаан жил амьдарчээ. Тэрбээр өнөөдөр Америкийн дэмжлэгтэйгээр Монголд бизнесийн судалгаа анализ хийж буй эрдэм шинжилгээний мэргэжилтэн, судлаачдад зөвлөгөө өгч, хамтардаг байна. Тэрбээр төслийн шинэ боломжит санааг олж илрүүлэх, төслийн менежерийн хувьд ур чадвараа хэрхэн хөгжүүлэх тал дээр мэргэшсэн нэгэн билээ. Өнгөрсөн сарын 21-нд Марк Тассе “Төслийн менежер болон багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх” сэдвийн дор сонирхолтой илтгэлийг “Төслийн удирдлагын анхдугаар чуулган” дээр тавьсан билээ. Энэ үеэр манай сэтгүүл түүнтэй ярилцах боломж олдсон билээ.

-Та чуулган дээр тавьсан илтгэлийнхээ гол санааг манай уншигчдад хүргэхгүй юу?

-Миний илтгэл АНУ болон Канадын Засгийн газар хэрхэн төслийн удирдлагыг хэрэгжүүлдэг талаар байлаа. Тэдний хувьд үйл ажиллагаандаа харилцаа холбоо, бодит үр дүнг ихээхэн чухалчилдаг. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монголд эрс өөрчлөлтүүд олон гарлаа. Дэлхийн эдийн засаг руу харайлган орж байна гэж хэлж болно. Дэлхийн эдийн засгийн хүрээлэлд өрсөлдөхийн тулд тухайн орчинтой нь зохицож ажиллаж сурах хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, түншүүдтэйгээ үл ойлголцолд хүрсэн нь Монголын Засгийн газартай хамтарч ажиллаж байх үед үйл ажиллагааны дунд ямар нэг зүйл гарч ирэхвий гэдэг сэрэмжлэлээс үүдэлтэй. Гадныхны ямар нэг үйл ажиллагаа явуулахдаа баримтлаад дадчихсэн стандарт гэдэг зүйл Монголд одоо хөгжиж байгаа учраас аль аль талаасаа харилцан ойлголцлын хүрээнд зөрүү гараад байна.

-Өнөөдрийн байдлаар Монголд олон төсөл хэрэгжиж байгаагийн зэрэгцээ шинээр хэрэгжих гэж байна. Тэгвэл төслийн энэ их урсгалыг хэрхэн тэнцвэржүүлвэл зохилтой вэ?

-Дээр дурьдсан асуудлаас гадна дараагийн нэг асуудал нь төслийн загварчлал, үнэлгээ, хяналтыг хэрхэн хийж байгаа нь юм. Хэрвээ оролцогч талууд ондоо стандартын дагуу ажиллаад, хэрэгжүүлэх гээд байвал явцын дунд ахиад л зөрчил гарч ирнэ. Гаднын компаниудын талаарх шүүмжлэлүүдийг харвал, зохицуулалт, төлөвлөгөө, цаг хугацааг хэт барих гэж зүтгэдэг уян хатан биш гэдэг. Хүлээж байсан шиг ажил хурдан урагшлахгүй болоход үйл явц удааширдаг. Европод зохиогдсон олон улсын тэмцээн үүний тод жишээ. Олон орноос ирсэн багуудад нэг цагийн хугацаанд ширээн дээр бэлдсэн материалаар тодорхой байгууламж бүтээх даалгавар оноосон. Хойд Америкийн баг бүрэлдэхүүн хэсгүүдээ нийлүүлж эхэлсэн бол Францууд маргалдаж, өөр, өөрсдийнхөөрөө зүтгэж байлаа. Харин Германы баг өгөгдсөн цагийнхаа 40 минутыг загвар, хар зураг, төлөвлөлт зэрэг төслийнхөө загварчлалд зарцуулсан. Хүн бүр тэднийг төлөвлөлтөд хэт их цаг зарцуулсан учир амжихгүй гэж бодож байв. Гэсэн ч төслийн үйл явцыг нарийн тооцож чадсан учир тэд үлдсэн 20 минутанд хамгийн өндөр цамхагийг барьж ▶

► чадсан юм. Өөр хоорондоо адилгүй соёлуудын ялгаа зөрчлийн эх үүсвэр байдаг. Гэсэн ч тэдний хувьд нөөц боломж юу болох, цаг хугацааг хэрхэн тааруулах вэ, зохион байгуулалтаа яаж хийх вэ гэдгээ мэдэж байв.

Нэн тэргүүнд улс орнуудын тогтсон дадал, соёлын ялгаатай зохицох арга замыг бий болгох нь зүйтэй. Энэ бол соёлуудын уулзах цэг. Тиймээс ганцхан орны соёлын дагуу явдаг үйл явц биш. АНУ-ын Төслийн удирдлагын хүрээлэн өөр хоорондоо адилгүй 100 гаруй орныг хамардаг. Гэсэн ч дэлхий даяараа хэрэглэж болох олон улсын нэгдсэн стандартыг бий болгосон. Энэ бол соёлын ялгаанаас үүдэлтэй дээрх асуудлуудтай зохицож болох стандартыг хэн ч бий болгож болох энгийн үйл явц байдаг. Хүлээсэн үр ашгаа хүртэж чадахгүйгээр цаг мөнгөө үрээд байгаа тохиолдлууд байсаар байна. Иймээс л үнэхээр дээрх байдалд хүрсэн эсэхийг үнэлж дүгнэх тогтолцоо хэрэг болдог.

-Цаг, мөнгө, эцсийн зорилгодоо хүрэх нь сайн төслийн шинж гэж та илтгэлдээ дурьдсан. Тэгвэл төсөв, хугацаа нь хэтэрч, хариуцлагын асуудал яригдаж байгаа Оюутолгой төсөл муу жишээ болж таарч байна уу, Энэ төслийн алдаатай хэсэг нь хаана байна вэ?

-Анх хийсэн гэрээнд заагдсан хүлээлтүүд байрнаасаа ухарч байна. Дээрх хүлээлтүүдийн хүрээнд төслийн “нэг хэл” байсан уу, урьдчилж харах боломжгүй үйл явдлуудад арга хэмжээ авсан уу?

Олон төслийн үйл ажиллагаанд том цохилт өгсөн 2008 оны эдийн засгийн нуруултыг хэн ч урьдчилж хараагүй. Цөөнгүй асуудлыг дагуулсан Хятадын эдийн засгийн удаашралыг хэн ч тааж хэлээгүй. Төлөвлөлтийн үйл явцаа зохих ном журмын дагуу хийж, асуудлыг бүхэлд нь харж, асуудлыг тооцохгүй аваас дээрх шиг гэнэтийн үйл явдалд бүдэрдэг. Энэ бол төлөвлөлтийн дундах жижиг чимхлүүр нэмэлт хэсгүүд байдаг. Гэвч шаардагдах жижиг хэсгүүдийг нэмснээр томоохон өөрчлөлт бий болдог. Монголын хувьд оролцогч талуудын хүлээлт нь мөн жолоодлого нь ондоо өөр байх хандлагатай учир төслийн анх хийсэн төлөвлөлт өөр зүгт явчих гээд байдаг.

-Төслийн хэмжээнээс үүдэн төлөвлөлт төвөгтэй болдог вэ?

-Оюутолгой шиг хэмжээний асар том төслүүдийн хувьд цаг, төсөв хоёроо барина гэдэг их хэцүү. Төлөвлөснөөсөө хэтрэх нь энгийн үзэгдэл. Үүнээс илүүтэй төслийнхөө үндсэн зорилгыг барих нь чухал. Одоо харж буй нөхцөл бол тэд хэр хол явсан бэ гэдэгт төвлөрч байна. Хүлээж байсан нөхцөл байдал уу, эсвэл энгийн үзүүлэлтүүдээс хэт хол зөрөөд алслагдаад байна уу гэдэг юм. Хэрвээ сүүлийнх нь бол үүнийг асуудал гарч ирж гэж үзэж болно.

-Монголын төслийн менежерүүдэд нэн тэргүүнд та юу гэж зөвлөх вэ?

-Нэн тэргүүнд өгөх зөвлөгөө бол харилцаа, хамтын ажиллагаа. Харилцан ойлголцож, зорьж буй буй үр

дүнгээ тодорхойлж, нэгдэх нь нэн чухал. Бүгдээрээ төслийн хүрээнд ийм, ийм зүйлийг нэмье гэдэг саналаа гаргаад улмаар алийг нь нэмж, алийг нь төслийн үндсэн зорилготой авцалдахгүй байгаа учир хасч байгаагаа ярилцаад явах хэрэгтэй.

Шинэ төслийн менежерүүдэд тулгардаг хамгийн том бэрхшээл нь төслийн явцад гарч ирдэг таамаглаагүй сөрөг хүчин зүйл байдаг. Урт хугацааны төслүүд дээр энэ нь илүүтэй тохиолдох хандлагатай байдаг. Цаг хугацаа гэдэг аливаа зүйлийг төсөөлж байснаас өөр тийш нь эргүүлэх хүчин зүйл болох талтай.

-Төслийн удирдлагын хүрээнд хүмүүсээ сургах тал дээр юуг анхаарах вэ?

-Төслийн удирдлагын хүрээлэнгийн сайн талуудын нэг нь энэ. Мэдлэгээ шилжүүлэх, хүмүүсээ сургах асуудлыг их энгийн, хялбараар шийдэж өгсөн байдаг. Тиймээс Канадын Засгийн газар энэ тогтолцоог хүлээж авч, сургалтын хөтөлбөртөө шингээж эхэлсэн. Засаглалын хамгийн доогуур түвшинд явж байсан ч авч хэрэглэж болдог. Засгийн газрын ахмад албан хаагчдад ч адилхан зарчмаар зааж сургадаг давуу талтай. Учир нь төслийн хүрээлэнгийн ерөнхий зарчим нь ямар ч түвшинд ялгаагүй ижил. Өөр байх тохиолдол нь төслийн хэмжээ байдаг. Гэхдээ ямар ч аргаар эхэлсэн ижил төгсгөлтэй байдаг. Суурь чадвар л хамгийн чухал. Нэг стандартыг сонгож, хэрэгжүүлэхээс гадна дээд түвшний шийдвэр гаргагчдаас эхлэн энэ талын суурь ойлголтуудыг өгөх нь тэдний хувьд дээрх асуудлын хүрээнд шийдвэр гаргахад туслах учиртай.

-Төслийн удирдлагыг төлөвшүүлэхэд хэр их хугацаа шаарддаг бол?

-Ихэнх хөтөлбөрийн дагуу төслийг хэрхэн авч явах талаарх ойлголт өгч сургаж, хэрэгжүүлэхэд зургаан сар зарцуулдаг. Дэлхийн бусад оронд суурилдаг ажлын хэсгийнхэн монголчуудтай зөвлөхийн байр сууринаас хамтарч ажиллахад бэлэн байгаа. Төслийн удирдлагын хүрээлэнгийн сүлжээний ажлын нэг хэсэг бол энэ. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэхэд тань туслах тус байгууллагын 500 мянга гаруй мэргэжилтэн бас бий. Бусад улс оронд хэрэгжиж буй ижил төрлийн төслийн багынхантай ч холбогдож туршлага судалж болно. Хаанаас эхлэх вэ, яаж хийх вэ гэж асуухын оронд энэ боломж, нөөцийг ашиглах нь зүйтэй.

Энэ хурлын дараах монголчуудын нэн тэргүүнд хийх ёстой ажил юу байх вэ?

Засгийн газар нэн түрүүнд 15-20 хүн бүхий ажлын хэсэг байгуулж, тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу дадлагажуулж, улмаар тодорхой төслүүд хариуцуулах хэрэгтэй. Тэгээд юу болохыг нь хар, үр дүнг нь хэмж. Хэрэгжиж байгаа болон урьд нь хэрэгжсэн төслүүдтэй харьцуулж илүү сайн байж чадаж буй эсэхийг шалгаж болно. Амьдрал дээр хэрэгжүүлсэн нөхцөлд л тухайн ойлголт баталгаажина. Өөрөөр хэлбэл, яаж болох, болохгүйг мэдэж авна гэсэн үг. Тиймээс туршаад үз. ■

ИЛТГЭЛ

ШИЛДЭГ ТӨСЛИЙН НУУЦ

Г. ГАНТӨГС /Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн/
“Олон улсын сайн төслүүдээс суралцах нь” илтгэл.

Аливаа төсөл шийдлийг тодорхойлох, сонгон шалгаруулах, боловсруулах, гүйцэтгэх, ашиглалтад өгөх гэсэн таван үе шаттай байдаг. Төслийн үр өгөөж эхний хоёр үеэс шууд хамааралтай. Суурь буруу бол тухайн төсөл амжилтгүй болно гэсэн үг. Тухайлбал, шийдлээ буруу тодорхойлсон бөгөөд гүйцэтгэлийг сайн хийсэн байлаа гэж төсөөлье. Тэгвэл тухайн төслийг ашиглалтад өгснөөс хойш буюу ашиглаж эхлэх явцад өгөөжгүй болно гэсэн үг.

Одоогоор дэлхийд төслийн менежментийн дөрвөн томоохон институт ажиллаж байна. Үүнд, Олон улсын төслийн менежментийн холбоо, АНУ-ын төслийн менежментийн институт, Европын төслийн удирдлагын холбоо, Японы төслийн менежментийн холбоо зэрэг орно. Эдгээр институт нь дэлхийн шилдэг төслүүдийг гүйцэтгэж, шилдэг менежментийг явуулж чаддаг. Тэгвэл тэдний гүйцэтгэсэн олон шилдэг төслөөс хоёр томоохон төслийг энэ удаа танилцуулна. 2011 оны шилдэг төслөөр шалгарсан усны төсөл. Энэ нь 55 км урт шугам бүхий цэвэрлэх байгууламж байгуулах, 10 мянган акр газар ус цуглуулах талбай барих төсөл. Уг төсөл нь 200 сая ам.доллар хэмнэж, зургаан сарын өмнө төслийг бүрэн дуусгаж чадсан

гайхалтай амжилт үзүүлсэн.

Мөн өнгөрсөн онд Химийн зэвсгийг устгах төсөл шилдгээр шалгарсан байгаа. Уг төсөл маш хүнд ажил гэдгийг онцлох хэрэгтэй байх. Учир нь, 1000 агуулахад агуулагдаж байсан 220 мянган ширхэг химийн тэсрэх аюултай зэвсгийг төслийн багийнхан аюулгүй болгох ёстой байсан юм. Тийм ч учраас энэ бол дэлхийн хамгийн аюултай төслийн тоонд зүй ёсоор багтдаг. Тиймээс бид тухайн төслөөс амжилтын үзүүлэлтийг нь авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, зургаан сая доллараар хэмнэсэн төдийгүй хоёр сарын өмнө бүрэн хэрэгжиж дууссан аж. Энэ бүгдийн цаана маш олон хүчин зүйл бий.

Уг хоёр төслийг амжилттай дуусгахад таван үе шат бүхий есөн менежмент, 42 процесс харилцан уялдаатай байсан гэдгийг хэд хэдэн жишээнээс харж болно. Тухайлбал, төслийг заасан хугацаанаас өмнө дуусгах гол нууц нь хүний нөөцийн төлөвлөлтийг зөв хийж чадсанд байдаг. Харин үүнийхээ дараа харилцааны менежментийг өргөн хүрээтэй явуулсан байх жишээтэй. Тэр дундаа мэдээллийг түгээх ажиллагааг эрчимтэй өрнүүлсэн байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр ажлын үйл явцын тайланг хянаж байсан хүмүүст

Прейригийн усны төсөл /2011 оны шилдэг төсөл PMI/


Төслийн цар хүрээ: 55 км ус дамжуулах суваг болон цэвэрлэх байгууламж байгуулах, 10000 акр газар бүхий ус цуглуулах талбай бэлтгэх

Төсөл хэрэгжих хугацаа: 5 жил

Төсөвт өртөг: 854 сая ам.доллар



Химийн зэвсгийг устгах төсөл / 2012 оны шилдэг төсөл PMI



Төслийн цар хүрээ:

1000 агуулахад хадгалагдаж байгаа

220000 ширхэг химийн зэвсгийг устгах

Төслийн хугацаа: 4 жил



- мэдээлэл шуурхай хүрч байсан хэрэг. Мэдээлэл хэдий чинээ хурдан авна шийдвэр төдий чинээ хурдан гарна. Ингэснээр төслийн ажлын ашигтай үйл ажиллагаа эрчимжиж, хугацаанаас өмнө дууссан хэрэг. Харин өртөг хэмнэхийн тулд төслийн баг, гүйцэтгэгч хоёрыг нэг баг гэж үзсэн. Харин Монголд төслийн баг нь гүйцэтгэгчийг удирдах замаар ажилладаг. Гэтэл усны төсөл дээр талууд багийн системээр үйл ажиллагаагаа явуулсан тул ажлын бүтээмж өндөр болсон юм. Ажлын бүтээмж хэдий өндөр байна төдий чинээ гарах өртөг бага гарч байгаа хэрэг.

Дараагийн чухал асуудал бол төслийг хүлээлгэж өгсний дараа нэмэлт ажил гараагүй. Энэ нь агуулгын менежменттэй холбоотой. Манайд агуулгын менежмент алдаатай байдаг учраас нэмэлт ажил их гардаг. Агуулга алдаатай байна гэдэг нь төсөл цаашаа амжилттай хэрэгжихгүй гэсэн үг юм. Агуулгын менежментэд хамгийн чухал зүйл бол цаг хугацаа болон ажлын цар хүрээгээ бүрэн зөв тодорхойлох. Ингэснээр ажлын багцын жагсаалт болон үйл ажиллагааны тодорхойлолт зөв гардаг. Дээрх хоёр төсөл энэ тал дээр маш сайн ажилласан гэж хэлж болно. Гэхдээ ажлын багцыг гаргах явцад нэг сонин зүйл ажиглагдсан. Энэ нь нийт ажлын 70 орчим хувь нь туслан гүйцэтгэгчийн ажил гэдэг дүгнэлт гарсан байдаг. Тиймээс туслан гүйцэтгэгчийн ажилд тулгуурлан нийт шаардах цаг хугацааг тооцож чадсанаар илүү бодитой дүгнэлт гарсан.

Эрсдэлийг хэрхэн амжилттай давах талаар хэдэн зүйл хэлье. Дээр дурдсан 220 мянган ширхэг химийн тэсрэх аюултай зэвсгийг төслийн багийнхан аюулгүй болгосон нь 220 мянган эрсдэлийг давсан гайхалтай сайн жишээ. Захиалагч гүйцэтгэгчид аюулгүй ажиллах шаардлагыг нэгдүгээрт тавьсан юм. Үр дүнд гүйцэтгэгч эрсдэлийн үнэлгээг бодитой гаргах шаардлагатай болсон. Гэхдээ эрсдэлийг бодитой тооцох бол эхний ажил. Дараагийн том хүчин зүйл бол эрсдэлийн эсрэг авах арга хэмжээг нарийн тооцоолж чадсанд байгаа юм. Гэхдээ төслийг гүйцэтгэх явцад нэг доголдол илэрсэн байдаг. Тухайн үед төслийн менежментийн баг эрсдэл учирч болзошгүй гэх байр суурьтай байсан. Гэхдээ эрсдэл гарвал нэн даруй хариу арга хэмжээ авна гэж төлөвлөсөн байдаг.

Гэтэл төслийн удирдлагын баг байр суурийн өөрчлөлт буюу бид ямар ч эрсдэлгүйгээр тухайн ажлыг хийж дуусгана гэсэн тодорхойлолт гаргаж үйл ажиллагааг хоёр сар зогсоосон. Энэ явцад нийт ажилчдыг аюулгүй ажиллах үйл явцтай нарийн танилцуулж, бид ямар нэгэн эрсдэл гаргаж болохгүй гэх ойлголтыг төслийн багийнханд суулгасан нь эрсдэлгүй ажиллах гол нөхцөл болсон юм. Гэхдээ энэ бол ердөө л нэг хэсэг. Үүний ард нөгөө л таван үе шат бүхий есөн менежмент, 42 процесс байгаа. Үүний ард нуугдаж байгаа зүйл бол бичиг баримт, банкны үнэт зүйл хөрөнгө, заавар, дүрэм журам, төлөвлөгөө. Энэ нь байгууллагын процесс дахь хөрөнгө юм. Тиймээс монголчууд зайлшгүй энэ талын мэдлэгтэй болох хэрэгтэй. Төслийн бүх үйл ажиллагаанд байгууллагын процесс дахь хөрөнгө тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Эндээс харахад төсөл амжилттай хэрэгжүүлэхийн тулд ямар олон хүчин зүйл шалтгаалдаг нь харагдаж байгаа юм.

Төсөл амжилттай хэрэгжсэний дараа сурч мэдсэн зүйлийнхээ жагсаалтыг гаргадаг. Үүний дараа төслийн хүлээн зөвшөөрөгдсөн үр дүн, өөрчлөлтийн тайланг нэгтгээд мэдлэгийн хэлэлцүүлэг өрнүүлсэн. Эцэст нь хаалтын тайлан хийдэг. Эндээс хамгийн чухал нь төслийг амжилттай хэрэгжүүлсэн туршлага юм. Төслийн хуримтлагдсан туршлагын сан үүснэ гэдэг байгууллагын процесс дахь хөрөнгийг шинэчлэх, сайжруулах үндэс болдог. Тэгэхээр төслийн удирдлагын мэдлэгийн 50 хувь нь мэдлэг бол 50 хувь нь сайн туршлагын хамтын үр дүн байдаг. Үүн дээр нэмэх нь суралцах процесс юм. Эдгээр хүчин зүйлтэй холбоотой төслийн удирдлагын мэдлэг хуримтлагддаг. Харин төслийн удирдлагын мэдлэг нь байгууллагын процесс дахь хөрөнгийн хамгийн чухал хэсэг. Тиймээс монголчууд олон улсын сайн төслөөс суралцахаас гадна өөрсдийн хэрэгжүүлсэн төслөөс суралцах нь чухал юм.

Илтгэлийнхээ төгсгөлд “Та бүгдийн сурч мэдсэнээ тодорхойлох таван минутын уулзалт ирээдүйд хийх ажилд тань 10 амжилтыг дагуулах болтугай” гэж ерөөе. ■

ЭДИЙН ЗАСАГЧ БИЧИЖ БАЙНА

“ЧИНГИС БОНД”-ЫН ЭЕРЭГ БА СӨРӨГ ТАЛ



Б.МӨНХЗАЯА (PH.D)
СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш

Улс орны их бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын гаргасан “Чингис бонд”-ын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр янз бүрийн мэдээлэл түгэх боллоо. Бонд гаргасан үеэс өнөөдрийг хүртэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан 40 орчим нийтлэл, мэдээг судлан үзэхэд гуравны хоёр нь эерэг, үлдсэн нь сөрөг мэдээлэл байна. Мэдээллүүд нэг талыг хэт баримталсан ба тэнцвэртэй мэдээлэл бүрэн хүргэхгүй байгаа нь ажиглагдсан.

Аливаа зүйлд эерэг, сөрөг нөлөө байдгийн адил анх удаа гаргаж буй Засгийн газрын бондын санхүүжилт манай улсын эдийн засаг, санхүүд эерэг, сөрөг нөлөө үзүүлнэ. Асуудлын гол нь эерэг нөлөө хэрхэн бий болгох, сөрөг нөлөөнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх явдал юм. Бонд амжилттай болох, алдах магадлал нь зоосны сүлд, тоо буух магадлалтай адил тавь, тавин хувь юм. Энэхүү нийтлэлдээ “Чингис бонд”-ын талаарх зарим мэдээллийг тооцоо судалгааны үндсэн дээр аль нэг талыг барилгүй тэнцвэртэй байдлаар мэдээлэл хүргэхийг зорилоо.

Бонд санхүүжилтийн сонгодог эх үүсвэр мөн үү?

Аливаа улсын бүтээн байгуулалт, хөгжил дэвшил нь түүнийг санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрээс ихээхэн шалтгаалдаг. Хөрөнгө мөнгөгүй гэсэн шалтгаанаар олон жил их бүтээн байгуулалтын үйл ажиллагаа зогсонги

байдалтай явж ирсэн. Харин өнгөрсөн онд манай улс дэлхийн улс, орнуудын Засгийн газруудын түгээмэл хэрэглэдэг “Бонд”-ын санхүүжилтийг сонгосон.

XVII зууны үед дайныг санхүүжүүлэх эх үүсвэр олох зорилгоор Европын улсуудад анх хэрэглэж байсан Засгийн газрын бонд өнөө үед улс, орнуудын Засгийн газрын төсвийн зардлаа санхүүжүүлэх хэрэгсэл болон ашиглагдаж байна. Дэлхийн түүхэнд гарсан томоохон хямралуудын шалтгааныг судлан үзвэл XIX зууны хямралын долоо орчим хувь, XX зууны хямралын 10 орчим, XXI зууны хямралын 12 орчим хувь улсын өр байжээ. Эндээс үзвэл улсын өрийн хэмжээ нэмэгдэх нь санхүүгийн хямрал үүсгэх шалтгаан болох ба сүүлийн жилүүдэд үзүүлэх нөлөө нь улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал, 1807 оноос хойш үргэлжилсэн Gunboat-ын дайныг санхүүжүүлснээс 1813 онд Дани улс олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан бондын өрөө төлөх боломжгүй болж, улмаар төсвийн хэт их хэмжээний алдагдалд орж байсан, 1980 оны Латин Америкийн Мексикт зээлүүлсэн өрөөс үүдэлтэй санхүүгийн хямрал, 2010 оны Европын холбооны Португал, Ирланд, Грек, Испани, Бельги улсын Засгийн газрын өрөөс улбаатай эдийн засгийн уналтуудыг нэрлэж болно. Эндээс бондын санхүүжилт нь улсын санхүүгийн системийг унагах хэмжээний эрсдэлтэй хэрэгсэл гэж дүгнэж болохоор байна.

Дэлхий дээр 85 их наяд ам.долларын Засгийн газрын бонд байдаг гэсэн статистик байдаг. Бондын санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлж байгаа улс, орнууд ч олон байна. Тиймээс бид түүхэнд гарч байсан эдгээр муу кейсийг

▶ давтах биш харин үр ашгаа өгөх төслүүдийг л санхүүжүүлэх шаардлагатай байна.

Ямар төслүүдийг санхүүжүүлэх вэ?

Бонд нь өрийн нэг хэлбэр ба тухайн өрийг төлөх хэмжээний үйл ажиллагаа явуулахгүй бол үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлээгүй тохиолдолд манай улс өрийн дарамтад орох, улмаар дараагийн санхүүгийн хямрал үүсгэх гол шалтгаан болж болзошгүй юм. Чингис бондын хүүний төлбөрт бид жилд 75.0 сая ам.доллар буюу 108.0 тэрбум төгрөг, өдөрт 208.3 мянган ам.доллар буюу 300.0 сая төгрөг төлнө. (Хүснэгт1)

Хүснэгт-1. Бондын хүүний төлбөрийн тооцоолол

Хугацааны ангилал	Хүүний төлбөрийн хэмжээ /ам.доллараар/	Хүүний төлбөрийн хэмжээ* /Төгрөгөөр/
Жилд	75,000,000	108,000,000,000
Хагас жилд	37,500,000	54,000,000,000
Сард	625,000	9,000,000,000
Өдөрт	208,333	300,000,000
Тайлбар: * - USD/MNT=1440 гэж тооцов.		

Тиймээс санхүүжүүлэх төсөлд тавих гол шалгуур нь хүүний төлбөрийг бүрэн нөхөөд ашигтай байх шаардлагатай болж байна.

Бондыг бид амжилттай гаргасан уу?

Чингис бондыг олон улсын санхүүгийн зах зээл дээр бид анх удаа амжилттай гаргалаа гэх мэдээллийг Засгийн газраас мэдээлж байгаа билээ. Бондын нэрлэсэн үнээс 10 дахин их хэмжээний захиалга ирсэн нь гадаадын хөрөнгө оруулагчид манай улсыг ихээхэн сонирхож байгааг харуулж байна. Сонирхлыг нь татсан үндсэн шалтгаан нь бондын хүү ба энэ нь тухайн улсын зэрэглэлээс хамаардаг. Зэрэглэл нь тухайн улсын Засгийн газрын төлбөрөө хугацаандаа төлөх магадлал, эрсдэлийн түвшинг харуулдаг ба S and P, Moody's, Fitch зэрэг зэрэглэл тогтоодог байгууллагын үнэлгээг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг. Зэрэглэл өндөртэй улс нь эрсдэл багатай тул бондын хүү хамгийн бага байх бөгөөд зэрэглэл буурах тусам хүү өсдөг. Манай улсын гаргасан тав, 10 жилийн хугацаатай бондын хүү зарим улсынхтай харьцуулан үзлээ. (Хүснэгт 2)

Манай улс хэдийгээр ВВ- гэсэн зэрэглэлд байгаа ч харьцангуй бага хүүтэй бонд гаргажээ. Тухайлбал, Чили, Орос, Колумб зэрэг улсууд манай улсаас дээгүүр зэрэглэлтэй ч манай бондоос Засгийн газрын бондын хүү нь өндөр байна. Бондын нэрлэсэн хүү харьцангуй бага гэж хэлж болох ч ам.доллартай харьцуулахад төгрөгийн ханш сүүлийн үед суларч байгаа нь бондын бодит өгөөжийг нэмэгдүүлнэ. Тухайлбал, Бонд гаргах үед ханш 1395 USD/MNT байсан бол эхний хүүний төлбөр хийгдэх болсон

Хүснэгт-2. Улс, орнуудын зэрэглэл ба Засгийн газрын бондын хүү

№	Улсын нэр	Улсын ?р/ ДНБ(%)	Улсын ?р/ ДНБ(%)	S&P Зэрэглэл	5 жилийн хугацаатай бондын х??	10 жилийн хугацаатай бондын х??
		2011	2012			
1	Germany	81.5	78.8	AAA	0.402%	1.373%
2	Hong Kong	33.8	33.1	AAA	0.530%	1.164%
3	Netherlands	66.2	70.1	AAA	0.570%	1.690%
4	Denmark	46.4	51.3	AAA	0.668%	1.477%
5	United Kingdom	82.4	88.374	AAA	0.823%	1.880%
6	Canada	84.9	84.6	AAA	1.350%	1.930%
7	Australia	22.8	24	AAA	2.763%	3.267%
8	Austria	72.2	73.9	AA+	0.060%	1.739%
9	France	86.2	89	AA+	0.731%	1.891%
10	United States	102.9	106.5	AA+	0.837%	1.968%
11	Qatar	31.4	29.5	AA	1.540%	2.870%
12	Japan	229.7	235.8	AA-	0.417%	0.877%
13	China	25.8	22	AA-	3.200%	3.470%
14	Chile	9.9	10	AA/A+	5.030%	5.090%
15	Czech Republic	41.4	43.9	AA/AA-	0.920%	1.580%
16	Malaysia	52.5	53.1	A/A-	3.080%	3.080%
17	Poland	55.3	55.6	A	2.885%	3.332%
18	Mexico	43.8	42.8	A-/BBB	4.240%	4.720%
19	Brazil	66.1	65	A-/BBB	9.390%	9.970%
20	South Africa	38.7	39.9	A-/BBB+	5.630%	6.410%
21	Thailand	41.6	44.3	A-/BBB+	2.840%	3.290%
22	Peru	21.6	20.7	BBB+	2.700%	4.030%
23	Italy	120.1	123.3	BBB+	2.787%	3.921%
24	Spain	68.4	79	BBB+	2.948%	4.196%
25	Russia	9.6	8.3	BBB+/BBB	6.150%	6.650%
26	Colombia	34.6	32.3	BBB+/BBB-	5.610%	6.080%
27	Turkey	39.4	36	BBB-/BB	5.740%	6.190%

Эхсүлг: http://www.investing.com/rates-bonds/world-government-bonds?maturity_from=130&maturity_to=180

<http://www.nationsonline.org/oneworld/country-government-gross-debt.htm>

өнөө үед ханш 1440 USD/MNT болтлоо өссөн нь таван жилийн хугацаатай бондын бодит өгөөжийг 7.9 хувь, 10 жилийн хугацаатай бондын бодит өгөөжийг 8.37 хувь хүртэл нэмэгдүүлж байна. Цаашид ам.долларын ханш чангарах тусам бидний хямд өртөгтэй бондын бодит хүү нэмэгдсээр байх нь ээ.

“Бондыг авсан бүс нутгийн тухайд Азийн улсууд нийт бондын 29 хувийг, Европ 26-32 хувийг, АНУ 40-45 хувийг нь тус тус авсан” гэх мэдээлэл байна. Эдгээр хөрөнгө оруулагчдын хувьд ВВ- зэрэглэл нь төлбөрөө хугацаандаа төлөх эрсдэл өндөртэй зэрэглэл боловч, хөрөнгө оруулалтын багцаа тараан байршуулах, ашгаа нэмэгдүүлэх боломжит сонголт болно. Чингис бонд нь эдгээр хөрөнгө оруулагчийн багцын 1-3 орчим хувийг эзэлж байгаа юм. ▶▶

► Бондын төлбөр хийх нөхцөл бидэнд таатай юу?

Бондын санхүүжилтийн хувьд хүүний түвшнээс гадна төлбөр хийгдэх нөхцөл нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татдаг. Засгийн газрын болон бусад компанийн бондын хувьд төлбөр хийгдэх нөхцөл нь харилцан адилгүй байх боловч ихэвчлэн жил бүр хүүгээ төлдөг, хугацааны эцэст үндсэн төлбөрөө төлдөг гэсэн нөхцөлтэй байдаг. Харин “Чингис бонд”-ын хувьд хагас жил бүр хүүгээ төлдөг гэсэн нөхцөлөөр гаргасан. Энэ нь хөрөнгө оруулагч талаас авч үзвэл нэлээд ашигтай нөхцөл боловч бондын санхүүжилтийг ашиглаж байгаа бодний хувьд тийм ч таатай нөхцөл биш юм. Учир нь хагас жилийн өмнө эсвэл дараа төлөх мөнгөний үнэ цэнэ ялгаатай байдаг. Мөн эдгээр нөхцөлийн жигнэсэн дундаж хугацаа (ЖДХ) ч ялгаатай байна. (Хүснэгт3)

Хүснэгт-3. Бондын жигнэсэн дундаж хугацаа

Төлбөрийн нөхцөл	5 жилийн хугацаатай бондын ЖДХ	10 жилийн хугацаатай бондын ЖДХ
Хүүг хагас жил бүр төлдөг	4.509	7.947
Хүүг жил бүр төлдөг	4.566	8.068

ЖДХ гэдэг нь бондын үндсэн төлбөр төлөгдөх дундаж хугацааг илэрхийлэх ба хугацаа нь бага байх тусам бондын үндсэн төлбөрийг богино хугацаанд төлөөд үлдсэн хугацаанд хүүгээ төлнө. Тухайлбал, таван жилийн хугацаатай бондын хүүг хагас жилд төлнө гэсэн нөхцөлөөр гаргаснаар ЖДХ нь 4.509 жил гарч байна. Хэрэв хүү жилд нэг удаа төлдөг гэсэн нөхцөлтэй байсан бол ЖДХ нь 4.566 жил болж нэмэгдэх буюу бид илүү урт хугацаанд бондыг үндсэн төлбөрийг ашиглах боломжтой байсныг харуулж байна. Цаашид 3.5 тэрбум ам.долларын бонд гаргахаар төлөвлөж буй бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлийг өөрт илүү тохиромжтой байдлаар (ЖДХ-г илүү урт байхаар) гаргах боломж байна.

Бондын санхүүжилтийн санхүүгийн системд үзүүлэх эерэг сөрөг нөлөө юу вэ?

Бондын санхүүжилт орж ирэх үед мөнгөний нийлүүлэлт, гадаад валютын нийлүүлэлт нэмэгдэнэ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь эдийн засгийн өсөлтийг бий болгох, хүүний түвшинг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, гадаад валютын ханшийг сулруулах, төгрөгийн ханшийг чангаруулах зэрэг эерэг нөлөөг эдийн засаг, санхүүгийн системд үзүүлж болох юм. Ингэж эерэг нөлөө үзүүлэх эсэх нь төрийн бодлого, төслүүдийн үр ашиг, хэрэгжилтэд



тавих хяналт зэргээс ихээхэн шалтгаална.

Бондын хүүний төлбөрийг хагас жил бүр валютаар хөрөнгө оруулагчдад төлөх ба төлбөр хийх хугацаанд тодорхой хэмжээний валют гадагшилж, нийлүүлэлт буурах юм. Таван жилийн хугацаатай бондын үндсэн төлбөрийг 2018 онд, арван жилийн хугацаатай бондын үндсэн төлбөрийг 2023 онд төлөх ба энэ үеүдэд мөн л валютын нийлүүлэлт буурна.

Валютын нийлүүлэлт буурах нь төгрөгийн ханшийг сулруулах аюултай юм. Бондын төлбөр хийгдэх дээрх хугацаанд валютын ханш огцом унавал үүнээс үүдэн санхүүгийн хямрал үүсгэж болзошгүй юм. Тухайлбал, 1997 оны Азийн санхүүгийн хямралын гол шалтгаан нь гадаад валютын нийлүүлэлт бууралтаас үүдэлтэй дотоодын валютын ханшийн огцом уналт байсан. Тиймээс бондын төлбөр хийгдэх үеүдэд валютын нийлүүлэлтийг тогтвортой барих, дотоодын үйлдвэрлэл, экспорт нэмэгдүүлэх замаар төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах зэрэг бодлогыг авч хэрэгжүүлснээр дараагийн санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлж болох юм.

“Чингис” бондын санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, эдийн засгийн өсөлтөө дэмжих бодлого баримтална гэж төр засагтаа найдаж байна. Мөн зарцуулалт, түүний үр ашгийн талаарх үнэн бодит, тэнцвэртэй мэдээлэл ард иргэдэд хэрэгтэй байгааг энэ дашрамд хэлье. ■

ТӨСӨЛ

“ЧИНГИС БОНД”-ООС САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД

“Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төсөл:

- 2016 он гэхэд 50 сая орчим литр үнээний сүү боловсруулна.
- Нэмүү өртөг шингэсэн, импортыг орлох экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Улаанбаатар хотын хүн амын хэрэгцээнд нийлүүлнэ.
- Олон улсын стандартын шаардлагад нийцсэн сүү боловсруулах үйлдвэрүүд байгуулагдана.
- 2013 онд “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төсөлд “Чингис бонд”-оос 27.7 сая ам.долларын санхүүжилт хийнэ.



“Өвлийн хүлэмж барих” төсөл:

- 20 га хүлэмж байгуулснаар жилд импортолж буй өргөст хэмх, улаан лооль, гүзээлзгэнийг 100 хувь, амтат чинжүүг 65 хувь дотооддоо үйлдвэрлэнэ.
- 2014, 2015 онд Дархан, Эрдэнэт бусад аймгийн төвийн хэрэгцээнд нэмж 12.0 га хүлэмж тарьж бусад төрлийн хүлэмжүүдтэй хавсарч 2015 оноос импортын нарийн ногоог дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангадаг болно.
- Жилийн турш хүнсний ногооны хангамж сайжирна.
- Орчин үеийн техник, технологи нэвтэрнэ.
- 2013 онд “Өвлийн хүлэмж барих” төсөлд “Чингис бонд”-оос 17.4 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төсөл:

- Ноосыг 100 хувь дотооддоо боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Ажлын байрыг 15 мянгад хүргэнэ.
- Жилийн үйлдвэрлэлтийг 250 тэрбум төгрөгт хүргэнэ.
- 2013 онд “Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төсөлд “Чингис бонд”-оос 45 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“Оёдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төсөл:

- Дотоодын үйлдвэрийн ноосон даавуугаар 520.0 мянган ширхэг сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэнэ.
- Орон нутаг, нийслэлд 30 гаруй оёдлын үйлдвэрү шинээр бий болж, 50 гаруй жижиг үйлдвэрүүд туслан гүйцэтгэгчээр ажиллах төлөвтэй байна.
- Сурагчийн дүрэмт хувцас болон бусад дүрэмт хувцас шаардлагатай байгууллагуудын хэрэгцээг дотооддоо үйлдвэрлэнэ.
- 2013 онд “Оёдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төсөлд “Чингис бонд”-оос 13.5 сая ам.долларын санхүүжилт хийнэ. »



“Ноолуурын салбарыг хөгжүүлэх” төсөл:

- 2013 онд нийт ноолуурын 50 хувийг үндэсний үйлдвэрүүд худалдан авч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- 2016 онд 3.2 сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн /80 хувийг экспортлох/, 978 мянган метр ноолууран даавуу тус тус үйлдвэрлэнэ.
- 2013 онд “Ноолуурын салбарыг хөгжүүлэх” төсөлд “Чингис бонд”-оос 68.8 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“Тавантолгойн цахилгаан станц” төсөл:

- Даланзадгад болон говийн бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангана .
- Нүүрс угаах үйлдвэрийн завсрын бүтээгдэхүүн болон эрчим хүчний нүүрс ашиглаж, нүүрсийг эцсийн бүтээгдэхүүн болгож, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Хүчин чадлаа өргөтгөснөөр Ухаа худаг, Баруун наран, Оюутолгойн уурхайг эрчим хүчээр хангана.
- 2013 онд “Тавантолгойн цахилгаан станц” төсөлд “Чингис бонд”-оос 50.0 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“Гудамж” төсөл:

Хотын төв:

- Улаанбаатар хотын 33 ширхэг “Т” маягийн уулзварыг “Дөрвөн зам”-ын уулзвар болгон шинэчилнэ.

Гэр хороолол:

- Тухайн хэсэгт зориулсан төлөвлөлт хийнэ.
- Төлөвлөлтийн дагуу автозам болон дэд бүтцийн тэнхлэгт орсон айлуудад нөхөн төлбөр олгоно.
- Инженерийн шугам сүлжээг хонгилын системээр шийднэ

“Хурдны зам” төсөл:

- Хурдны зам төсөл (Туул гол, Сэлбэ голын далангийн зам)
- 2013 онд “Гудамж” төсөлд “Чингис бонд”-оос 200.0 сая ам.долларын санхүүжилт хийнэ



“Шинэ төмөр зам” төсөл:

- Тавантолгой - Гашуунсухайтын чиглэлийн 267 км-ын урттай төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;
- Тавантолгой - Сайншанд - Баруун-Урт - Хөөт - Чойбалсан, Хөөт - Бичигтийн чиглэлийн 1500 км төмөр замын техникийн зураг төслийг хийж дуусгах;
- 2013 онд “Шинэ төмөр зам” төсөлд “Чингис бонд”-оос 200.0 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“2013 онд зургаан аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох” төсөл /Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Хөвсгөл/

- 2013 онд дээрх төсөлд “Чингис бонд”-оос 404.0 сая ам.долларын санхүүжилт хийнэ.

“Нийслэлийн орон сууцны дэд бүтцийг сайжруулах” төсөл:

- **Орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ**
 - Баянголын амины орон сууц,
 - “Буянт-Ухаа”
 - Ирээдүй цогцолбор
 - Орон сууцны VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын инженерийн шугам сүлжээ,
 - Берлин Эко
 - “Солонго”
 - Яармаг
- **Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ**
 - Дэнжийн 1000
 - Гандантэгчинлэн хийд
 - Дулаан хангамжийн шугам сүлжээний өргөтгөл
 - Сүхбаатар дүүргийн XV, XVI, XVII гэр хороолол
- **Баянзүрх дүүргийн XII гэр хороолол**
 - Чингэлтэй дүүргийн XIII, XV хороо, Хайлааст орчим
 - Сонгинохайрхан дүүргийн тав, зургадугаар хороо, Ханын материал орчим
 - Баянзүрх дүүргийн VIII, XVI хороо
 - Сонгинохайрхан дүүргийн X хороо
 - Чингэлтэй дүүргийн VII хороо

2013 онд “Нийслэлийн орон сууцны дэд бүтцийг сайжруулах” төсөлд “Чингис бонд”-оос 141.8 сая ам.долларын санхүүжилт хийнэ. ■

Эх сурвалж: ЭЗХЯ



ЕРТӨНЦ

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ИРЭЭДҮЙ

Төгсгөл. Түрүүч нь №10 (044) дугаарт

Орчуулсан Р.ГАНТУЛГА

Мэдээллийн урсгал

Өнгөрсөн арван жилд технологи болон хэрэглэгчийн төлөв байдалд хүчтэй өөрчлөлт орсны дүнд онлайн хэрэглэгчдийн үйлдэл болгоныг харуулсан олон жижиг бичлэг, сүүлдээ хязгааргүй олон бичлэгийг үйлдвэрлэжээ. Өнөөдөр дижитал видео бичлэг (DVR), дижитал тоглуулагч, жижиглэнгийн худалдааны тооцоо, кредит картны гүйлгээ, дуудлагын төвийн бичлэг болон бусад эх үүсвэрээс өгөгдлийн (data) арвин санд тогтмол оруулах болсон. Хэрэглэгчдийн харж, хийж байгаа зүйлсийг өмнө нь төсөөлөх боломжгүй байсан мэдээллийн арвин санд өдгөө маркетингийнхан нэвтрэх боломжтой болжээ.

Боломж нэгэнт тодорхой бол сорилттой тулгарах нь тодорхой. Энэ талаар нэртэй статистикч, зохиолч Нэйт Силвер “АНУ-ын конгрессийн номын сангийн номын цуглуулгатай адилхан хэмжээний мэдээ, мэдээллийг нэг секундэд гурван удаа үйлдвэрлэж байдаг. Гэхдээ ихэнх нь хэрэгцээгүй мэдээлэл. Эдгээрийг шүүж, боловсруулах сайн техник байхгүй бол үнэхээр асуудалтай” гэжээ.

Орчин үеийн ертөнцөд уламжлалт аналитик 1.0 хэмжүүрийн аргыг хэрэглэх хандлагаасаа салж чадахгүй байгаа маркетингийнхан олон бөгөөд энэ нь тэд өөрсдийгөө эрсдэлд оруулж буй хэрэг. Борлуулалтыг хэдэн арван хувьсагчтай харьцуулах зорилгоор жилд хэдэн удаа эргэж буцдаг, шинэ санаа, санаачилгыг дэмждэггүй энэ арга нь маш аюултай бөгөөд хоцрогдсон. Өнөөдөр дэлхий ▶



► дахинд үндэстэн дамнасан олон корпораци аналитик 2.0 хэмжүүрийг ашиглаж байна. Энэ нь бодит хугацаанд олон терабайт (нэг терабайт нь 100 гигабайттай тэнцүү) өгөгдөл, олон зуун хувьсагчийг боловсруулах хүчин чадалтай цогц хэмжүүр юм. Үүнийг хэрэглэснээр компаниуд өөрсдийн маркетингийн гүйцэтгэл, үйл ажиллагааны хувилбарын маш өндөр нягтшилтай зураглалыг гаргаж, явц дунд сурталчилгааны стратегия өөрчлөх боломж бүрдүүлдэг. Сүүлийн үед компьютерийн хүчин чадлыг олон зэргээр үржүүлэх боломжтой болж, файл хадгалах компьютерийн сүлжээнд суурилсан аналитик (cloud-based analytic) хийх, өгөгдлийг хямдхан хадгалах болсноор эдгээр таамаглах хэрэгсэл нь хэвлэл мэдээлэл, борлуулалтын сувгуудаар цацагдаж буй зар сурталчилгааны харилцан үйлчлэлийг хэмждэг байна. Эдгээр нь гаднаас дотогш чиглэсэн (exogenous) хувьсагчууд (өргөн хүрээтэй эдийн засаг, өрсөлдөөнт саналууд, цаг агаар гэх мэт) сурталчилгааны гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг нарийн тодорхойлдог. Энгийнээр илэрхийлбэл, үр дүнгээ өгч буй анализууд аль нь үнэхээр сайн ажиллаж байгааг харуулдаг. Эдгээр өгөгдлөөр-удирдуулсан гүн гүнзгий ойлголтын тусламжтайгаар компаниуд төсвөө цаашид одоогийн хэмжээнд барих, маркетингийн гүйцэтгэлээ 10-30 хувиар (заримдаа үүнээс ч их) сайжруулах боломжтой аж.

АНУ-ын Лос Анжелес мужийн Калифорнийн их сургуулийн маркетингийн профессор, “Market-Share” шинжилгээний компанийг үндэслэгчдийн нэг болох Доминик Ханссенсийн боловсруулсан математикийн шинэ загваруудыг ашиглан дэлхийн олон том компанийг бид аналитик 2.0 шийдлээр хангах болсон. Уг загварууд нь маркетингийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон борлуулалтын сувгуудаар үзүүлж буй нөлөө, мөн бизнесийн бүхий л хөдөлгөгч хүчний шууд болон шууд бус нөлөөллийн тоо хэмжээг тодорхойлдог. Программ хангамж нь алсын зайнаас интернэтээр удирдах компьютерийн сүлжээ (cloud computing)-г болон томоохон өгөгдлийн чадавхыг ашигладаг байна. Энд дурдагдаж буй тохиолдлуудыг “Harvard Business Review” сэтгүүл өөрсдийн үйлчлүүлэгч компаниудаас авч ашиглажээ. Гэхдээ сүүлийн үед дэвшилтэт аналитикийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагад нийцсэн “VivaKi”, “Omni-ture”, “DoubleClick” зэрэг компани гарч ирсээр байна.

Аналитик 2.0 загвар руу шилжих нь

Томоохон өгөгдөл, алсын зайнаас интернэтээр удирдах компьютерийн сүлжээ (cloud computing), аналитикийн шинэ загваруудыг нэгтгэсний дүнд аналитик 2.0 загвар нь орлогод үзүүлэх ►

► маркетингийн нөлөө рүү чиглэсэн цоо шинэ гүнзгий ойлголтоор хангаж өгдөг. Үүнд, хамаатуулах (attribution), оновчтой болгох (optimisation), байршуулах (allocation) гэсэн өргөн цар хүрээтэй гурван үйл ажиллагаа багтана.

-Хамаатуулах үйл ажиллагаа нь зар сурталчилгааны элемент нэг бүрийн дэмжлэгийн тоо, хэмжээг тодорхойлох үйл явц юм.

-Оновчтой болгох үйл ажиллагааг өөрөөр “дайны тоглоом” гэх бөгөөд энэ нь урьдчилан таамаглах аналитикийн хэрэгслийг ашиглан бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх хувилбарыг гаргана.

-Харин байршуулах үйл ажиллагаа нь оновчтой болгох хувилбаруудын дагуу нөөцийг маркетингийн үйл ажиллагаануудад бодит хугацаанд тарааж, дахин байршуулахыг хэлнэ.

Хэрэгжүүлэх таван алхам

Аналитик нь байшингийн урд биш, харин ард нь юу байгааг судлах ухаан тул өдөр тутмын стратегийн хөгжил болон үйл ажиллагаанд салшгүй холбоотой болжээ. Арав гаруй жилийн өмнө дижитал маркетингийн эхэн үеийн маркетингийн багийг санаачилж байсан гүйцэтгэх захирлууд одоо Маркетингийн гүйцэтгэх захирал (СМО)-ын оффисоо байгуулж, урагшилсаар. Хэмжүүрийг аль хэдийнэ мэдэх болсон тэдний хувьд өнөөгийн илүү өргөн цар хүрээтэй сурталчилгааны аналитик түүхий санагдаж, үргэлж л гайхшрух болжээ. Эдгээр шинэ захирлууд технологийн төсвийг голчлон хариуцах болсон бөгөөд зар сурталчилгааны хүрээнд баримтад суурилсан шийдвэр гаргах соёл бий болгож байна. Технологийн зөвлөх Гартнер ирэх таван жилд ихэнх Маркетингийн гүйцэтгэх захирал Технологийн гүйцэтгэх захирлууд (СТО)-аас илүү технологийн төсөвтэй болно гэж тооцоолж байгаа аж.

Технологи зайлшгүй шаардлагатай боловч энэ нь аливаа байгууллага аналитик 2.0 загвар руу шилжихэд хангалттай биш. Бид өөрсдийн туршлагаас харахад энэхүү шилжилтийг хийхийн тулд таван алхам шаардагдах бөгөөд жижиг, том аль ч компани хэрэгжүүлэх боломжтойгоороо онцлог юм.

Нэгдүгээрт, аналитик 2.0 загварыг байгууллагын хэмжээнд гүйцэтгэх төвшний (C-level) ивээн тэтгэгчээр дэмжүүлэн хэрэгжүүлэх. Мэдээж амжилттай хэрэгжих эсэхэд эргэлзсэн янз бүрийн эсэргүүцэлтэй тулгарах нь ойлгомжтой. Загварыг хэрэгжүүлэх эхэн шатанд алсын хараа, жигдрүүлэлтийг маш тодорхой, хялбар байлгахад дэмжлэг болох үүднээс гүйцэтгэх удирдлагын хяналтад байлгах нь чухал.

Хоёрдугаарт, дээрх хэрэгжилтийг хариуцах гол

албан тушаалтан болох аналитик сэтгэлгээтэй дарга эсхүл менежерийг томилох. Гэхдээ анализ хийх чадвартай, бодит байдал дээр нэр хүндтэй хүн байх шаардлагатай. Тэрбээр Маркетингийн гүйцэтгэх захиралд тайлагнаж, маркетинг болон санхүүгийн хоорондох олон мэргэжилтнээс бүрдсэн багийн нууцыг хадгалах үүрэгтэй. Төсөл өргөжихийн хэрээр уг албан тушаалтан нэгжүүдийн бизнес төлөвлөгөө, хүний нөөцийг байршуулах удирдамж өгөхөд дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаарт, нэн тэргүүнд асуух шаардлагатай асуултуудын жагсаалт гаргаж, байгууллагаа бүхэлд нь хамарсан өгөгдөл, мэдээллийн тооллого явуулах. Аналитик 2.0 загварыг амжилттай хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ур ухаан бол маркетингид биш, гол төлөв санхүүгээс хэрэглэгчийн үйлчилгээ хүртэлх олон үүрэгт агуулагдаж байдаг. Эдгээр өөр өөр өгөгдөл, мэдээллийн цогцыг олж тогтоон нэгтгэх, цаашид мэдээлэл цуглуулах систем бий болгох хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, тодорхой үйл ажиллагааны чиглэл, газар зүй, бүтээгдэхүүний бүлгийг хамруулсан концептийн баталгаатай жижиг зүйлээр эхлэх. Аль болох эрт амжилтад хүрэхийн тулд загваруудыг хязгаарлагдмал хүрээнд бий болгох.

Тавдугаарт, загваруудыг шургуу туршиж үзэх, гарсан үр дүнг тухайн загвартай дахин тулгаж, сайтар шалгах. Тухайлбал, хэрэв таны оновчтой болгох анализ зарим сурталчилгааны зардлыг телевизэд биш, онлайнд зарцуулбал борлуулалт сайжрах боломжтой гэсэн шийдэлд хүрвэл жижиг, орон нутгийн чанартай туршилт хийж, гарсан үр дүнг нь тооцооллоо цаашид улам боловсронгуй болгоход ашиглаарай.

Аливаа бизнес нь жижиглэнгийн ба онлайн худалдаа, нэмүү өртөг шингээж борлуулагчид, олон янзын бараа, газар зүй зэрэг олон төрлийн борлуулалтын сувгаар хүрээлэгдсэн байгаа тохиолдолд дотоодын баг, ажлын хэсгийн хувьд аналитик 2.0 арга нь гардан явуулахад илүү төвөгтэй байж магадгүй. Энэ тохиолдолд өвөрмөц анализ хийж, тооцоолох чадвартай борлуулагчид хэрэгтэй болдог. Гэхдээ ямар ч компани энэхүү аналитикт шаардлагатай дэд бүтцийг бий болгох, өөрт тохиромжтой маркетингийн соёлыг компанидаа нутагшуулах ажлыг эхлүүлэх боломжтой. Үүнд тулгарах сорилт бол тооцоолон бодохтой адил их хэмжээний бүтэц, зохион байгуулалтын ажил юм. Үүнтэй нэгэн адилаар “Маркетинг нь маш хурдан хугацаанд мэдлэгийн аян дайн, гүн гүнзгий ойлголт болж, аналитик 2.0 загвараас олж авах тэгш хэмгүй давуу тал болж байна” гэж бичээд хананд наах. Хойч үедээ зориулан аналитик хийдэггүй компани үүнийг хийдэг компанид эрт орой хэзээ нэгэн цагт гүйцэгдэх болно. ■

“Harvard Business Review” сэтгүүлээс орчуулав.

УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТ

ЗӨВ ХАНДЛАГА УР ЧАДВАРААС ЧУХАЛ



Х.ХУЛАН

Гудрун Хенне нь ХБНГУ-ын нийслэл Берлинд байрлах “Вивека интернэшнл” зөвлөх компанийг үүсгэн байгуулагч. Тэрбээр хуульч мэргэжилтэй бөгөөд докторын зэргээ Олон улсын хуулиар хамгаалсан байна. Хенне уг компаниа байгуулахаас өмнө арваад жилийн турш Монреал, Преториа, Амстердам, Берлин хотуудад удирдах албан тушаал хашиж байжээ. Бид түүнтэй Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Удирдлага, манлайлал” сургалтын үеэр ярилцсан юм.

-Аливаа компани хүний нөөцөө хөгжүүлэхэд юунд анхаарах ёстой вэ?

-Хүний нөөц бол тухайн байгууллагын амжилтын үндсэн элемент мөн. Аливаа байгууллагын удирдлага шинээр ажилтан авахдаа яг ямар хүн хэрэгтэй байгаагаа сайтар тунгаах хэрэгтэй. Тэгээд дараах асуултыг өөртөө тавьж үзээрэй “Шинэ ажилтны ажил үүргийн хуваарь юу байх вэ, уг ажлыг гүйцэтгэхэд ямар ур чадвартай хүн шаардлагатай байна вэ” гэж. Онцолж хэлэхэд, шинээр ажилтан авахдаа ур чадвараас илүү тухайн ажлын байр, компанид хандах түүний хандлага хамгийн чухал юм. Идэвх зүтгэлээр дүүрэн, хариуцлагатай, тухайн байгууллагад хувь нэмрээ оруулахад бэлэн байгаа хүнийг ажилд авах нь өгөөжтэй. Ур чадвар чухал ч ажлын явцад суралцах бүрэн боломжтой. Иймд би хувьдаа тухайн хүний хандлагыг нь харж байж ажилд авна. Мөн ажил олгогчийн зүгээс өөрийн өгч буй ажил үүргээс ямар хүлээлттэй байгаагаа нээлттэй хэлж хэвших хэрэгтэй.

-Компаниудад тулгарч буй бэрхшээлийн нэг бол сайн ажилтнаа хэрхэн тогтоох вэ гэсэн асуудал. Боловсон хүчнээ тогтвортой байлгахын тулд байгууллагаас ямар дэмжлэг үзүүлж болох вэ?

-Танай компанид урт хугацаанд тогтоож ажиллуулмаар сайн ажилтан байдаг бол тэр хүнийг ажилд нь юу тогтоож байна вэ гэдгийг эргэцүүлэн бод. Хүмүүс зөвхөн цалин мөнгөнд бус, ажлын байрны найрсаг орчин, байгууллагын нэгээхэн хэсэг болж буйдаа сэтгэл ханамжтай байгаа эсэх нь ихээхэн нөлөөлдөг. Мөн тэдгээр хүнд ахиж дэвших боломжийг нь олговоос зохистой. Эс тэгвээс ажилтнууд өндөр цалинтай ажил юм уу, илүү нэрд гарсан том компанид очиж ажиллах магадлал их байдаг. Жишээлбэл, Германд олон хүн нэрд гарсан “Адидас”, “Пума”, “Мерседес”, “Фольксваген” гэх мэт томоохон компанид ажиллах дуртай байдаг. Энэ нь тэдгээр компани нэрээ брэнд болгож чадсанд оршино.

-Удирдагч, манлайлагч гэж ямар хүмүүсийг хэлэх вэ. Энэ хоёр ойлголтын ялгааг Та юу гэж тайлбарлах вэ?

-Удирдагч, манлайлагч гэдэг нь нэг зоосны хоёр талыг илэрхийлдэг. Удирдагч буюу менежер бол компанийн үйл ажиллагаанд анхаарал тавьдаг. Өөрөөр хэлбэл,

► төсөв, ажлын хэрэгжилт хэрхэн явж буйг хянана. Мэдээж тухайн ажлаас гарах үр дүнг тооцно. Манлайлагч харин компанийн ирээдүйг харж алсын хараатай ажилладаг.

Хэрвээ зөвхөн үр дүнгийн төлөө ажиллах юм бол Монгол Улс шиг хурдацтай өөрчлөгдөж буй өрсөлдөхүйц орчинд нэг их урагшлахгүй. Иймд ажилдаа манлайллын зарчмыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Манлайлагч компаниа өнөөдрийн түвшинд бус, маргаашаар нь сэтгэж ямар өөрчлөлт хэрэгтэй байгааг олох шаардлагатай байдаг. Ингэснээр ажилчдаа өөрчлөлтөд бэлдэж, бүтээлч санаачилгатай ажилладаг. Ер нь нэг хүнд удирдагч, манлайлагчийн аль алиных нь зан чанар хэрэгтэй байдаг.

-Байгууллага доторх харилцааны талаар зөвлөхгүй юу?

-Байгууллага дотор мэдээлэл, харилцаа хоёрыг сайн ялгаж, салгаж байх хэрэгтэй. Мэдээлэл гэдэг нь тоо баримт, гарсан шийдвэрийг хэлдэг. Харилцаа бол хоёр талтай. Би юм хэллээ гэж бодоход, нөгөө талаас хариу хүлээнэ. Тэрхүү хариултаас шалтгаалж тайлбарлах, эргэн хариу өгөх шаардлага гардаг. Аливаа байгууллагад харилцаа холбоо чухал учир бүх түвшний ажиллагсдаа цуглуулаад хурал хийж, харилцан ярилцаж байх нь чухал, зөв арга юм. Нөгөөх нь сонирхсон сэдвийн дагуу асуулт тавьж хариулт авна. Сайн менежер асуулт асуугаад хариултыг олж авснаар болзошгүй бэрхшээлийг шийдвэрлэж өгдөг.


-Та сургалтаараа сайн менежментийн гурван арга байдаг гэж ярьсан. Эдгээрийг танилцуулна уу.

-Сайн менежмент гэж юуг хэлэх вэ гэдэг асуултыг хэдэн зуун жил дамнан ярилцасаар ирсэн. Гэхдээ ерөнхий гурван үзэл баримтлалыг голчилж үздэг. Нэгдүгээрт, ил тод, ойлгомжтой, биелүүлж болох зорилт дэвшүүлнэ.

Хоёрдугаарт, энэхүү зорилтод хүргэх хүмүүсийг урамшуулна. Ингэхдээ ажил үүргээ сайн биелүүлж байгаа ажилтнуудаа шагнан урамшуулж, муу биелүүлж байгааг нь сургана. Гуравдугаарт, ажлын гүйцэтгэлд мониторинг хийнэ. Юуг сайжруулах вэ, бид юунд суралцав, ямар өөрчлөлт хийж болохоор байгааг олж мэд.

-Компани хүний нөөцийн бодлогоо хэрхэн хэрэгжүүлбэл зохистой вэ?

-Энэ нь юуны өмнө ажиллагсдын гүйцэтгэж байгаа ажил, түүний чанараас хамааралтай. Байгууллагын дэг журамтай холбоотой бодлогыг хэрэгжүүлэхдээ хэт хатуу байх хэрэггүй. Ажиллагсад үр дүнтэй ажиллах нь л чухал юм. Өнөө үед ихэнх компани мэдлэгт түшиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Иймд тухайн компанийн гол үр дүн нь мэдлэгт суурилсан байдаг. Хүний нөөцийн ажилтны хувьд албаны дэг журмаас илүү бүтээлчээр ажиллах орчныг бүрдүүлэхэд анхаарваас зохистой. Жишээлбэл, пицца хийдэг компани компьютерийн программ хангамж бэлтгэдэг компаниас ялгаатай. Мэдээлэл технологийн ажилтанд программаа 09.00-17.00 хооронд л хийж гүйцэтгээрэй гэж хэлэхгүй. Харин тухайн ажилтны хувьд программ хангамж боловсруулахад хамгийн их үр дүн гаргаж бүтээлчээр ажиллахад тохиромжтой үе хэзээ байна вэ гэдгийг нь асуугаад, ажилласан цагийг нь тэмдэглэдэг. Гэхдээ мэдээж тухайн ажилтны ажлын үр дүнд нь мониторинг хийх хэрэгтэй. Үр дүн үнэхээр гарч байгаа тохиолдолд би бол тэр хүнд эрх чөлөөг нь олгоно. Нөгөө талаас яг заасан ажлын цагийн дотор багтаж гүйцэтгэх ажил үүргийн хуваарь байлгүй яахав. Тухайн ажилтан үр дүнгээ гаргаж, ажилдаа хариуцлагатай хандаж чадаж л байвал хийх үйл явцыг нь хянаад байх шаардлагагүй гэж боддог. ■



БОДЛОГЫН СУДАЛГАА

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАР

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхмийн ахлах багш Г.Баттулгын хийсэн “Монгол Улсын хөгжлийн загвар” судалгааны товч дүгнэлтийг хүргэж байна. Энэхүү судалгаанд Монгол Улс Ази болон Өрнөдийн орнуудын хөгжлийн аль загвараар замнах боломжтойг өгүүлжээ.

Хөтөч:

1. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 20 жилийг үдлээ. Азийн нүүдэлчин орон суурин соёл иргэншилтэй танилцаад даруй шинэ зууны босгыг элээсэн нь энэ. Өрнөдийн соёлыг нэвтрүүлснээс хойш манайх 90 гаруй жилийг туулсан байна. Гэвч бидний эдийн засгийн хөгжил, нөөц боломжийг авч үзвэл дэлхийн улс, орнуудын эхэнд бус адагт яваа нь нууц биш ээ. “Бид яагаад хөгжихгүй байна вэ?” гэсэн гайхаш тасарсан асуултад өнгөрсөн хугацаанд хариулсаар ирсэн ч эцсийн хариултыг нь өнөөг хүртэл олоогүй явна.

2. Ядуурал хүрээгээ тэлж, ажилгүйдэл өнгөрсөн хугацаанд дорвитой буурсангүй. “Монгол Улс эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн өмнө ирлээ” хэмээн онцлох боловч иргэдийн амьдралд наалдсан нь тун ховор. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бодит өсөлтийн үр шимийг бид төдийлэн хангалттай мэдэрсэнгүй.

3. Монгол Улс уул уурхайн баялгийн үүцээ задалж буй түүхийн торгон агшин өнөө тохиож буй. Харамсалтай нь хэрхэн хөгжих загвар, алсын хараа хараахан бидэнд алга. Дэлхийн улс орнуудын эдийн засгийн хөгжлийн загваруудыг ерөнхийд нь Азийн ба Өрнөдийн гэж ангилдаг. Өнөөдрийн манай орны эдийн засгийн загвар дээрх хоёр загварын алинд нь хамааралтайг яг таг хэлэх боломжгүй байна.

4. Хүснэгтээс харахад хоёр загварт адил төстэй гол зүйл нь эдийн засагт оролцогч гол институтуудыг өндөр хөгжүүлсэнд байна. Тэгвэл манай улсад институтуудын хөгжил сул хэвээр.

Эдийн засгийн хөгжлийн Азийн болон Өрнөдийн загварын бүдүүвч схем

Эдийн засагт оролцох төрийн оролцоо	Азийн эдийн засгийн хөгжлийн загвар	Өрнөдийн эдийн засгийн хөгжлийн загвар
	Эдийн засагт оролцох төрийн оролцоо харьцангуй их	Эдийн засагт оролцох төрийн оролцоо харьцангуй бага
	Макро түвшинд бодлого боловсруулахдаа төр давамгайлах	Макро түвшинд бодлого боловсруулахад хувийн хэвшил давамгайлах
Чөлөөт зах зээлийн байдал	Микро түвшинд бодлого боловсруулахад төрийн оролцоо харьцангуй өндөр	Микро түвшинд бодлого боловсруулахад төрийн оролцоо маш бага
	Бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа өндөр	Бизнесийн байгууллагын хооронд өрсөлдөөн өндөр
	Хэлцлийн зардал харьцангуй бага	Хэлцлийн зардал бага
Улс төрийн байдал	Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлоготой	Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хүчтэй бус
	Улс төрийн эрх чөлөө бага	Улстөрийн эрх чөлөө их
	Улс төрийн сөрөг хүчний саад бага	Улс төрийн сөрөг хүчний саад их

Үүнийг эдийн засгийн онолын нэг урсгал болох “Институтын онол”-оор тайлбарлаж болно. Институтуудын хөгжлийн гол хөшүүрэг бол хууль, эрх зүйн нарийн систем, мэдлэг болон технологид суурилсан эдийн засгийн бодлого юм. Тухайн улс орны хүний хөгжлийн индекс нь мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг нь харуулдаг бол өрсөлдөх чадварын индекс нь технологид суурилсан эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог гэж үздэг.

5. Өөрчлөгдөх боломжгүй дотоод нөхцөл нь манай улсын эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, хөдөө аж ахуй. Гадаад хүчин зүйлийн нөлөө ч бас бий. Энэ нь Монгол Улсыг эдийн засгийн ямар бүтэцтэй улс байлгахыг зөвлөж, чиглүүлэх, хөрөнгө оруулж буй гаднын улс, орнуудын бодлогоос хамаарах нь дамжиггүй. Мэдээж Монгол Улс дээрх хоёр салбарт амжилттай ажиллаж болох ч түүнээс олох орлого нь зөвхөн тухайн салбартаа болон нийгмийн халамжинд ▶▶

▸ зарцуулах аваас “Баялгийн хараал” бодитоор бий болох магадлал өндөр. Тиймээс бид эдгээр салбараас олох ашгаа илүү ирээдүйтэй, өндөр бүтээмжтэй шинэ тутам хөгжиж байгаа салбарт хөрөнгө оруулалт хийх замаар хуваарилах нь чухал байна. Өөрөөр хэлбэл, инновацийг нэвтрүүлсэн мэдлэг болон технологид суурилсан эдийн засагт хөрөнгө оруулах нь чухал болоод байна.

Жишээ:

-Азийн загварыг сонговол богино хугацаанд хурдацтай хөгжих боломжтой бол Өрнөдийг сонгосон тохиолдолд харьцангуй урт хугацаанд хөгжих нөхцөл бүрддэг болохыг хөгжсөн Азийн бар орнуудын жишээ харуулж байна. Жишээлбэл, Венесуэл болон Хонконгийг харьцуулахад тэс өөр ялгаа гарч байна. Хонконг ямар ч байгалийн нөөцгүй бол Венесуэл байгалийн асар их нөөцтэй төдийгүй дэлхийн байгалийн хий, газрын тосны томоохон үйлдвэрлэгч. Гэвч хөгжлийн үзүүлэлтээр Хонконг илүүрхэх аж. Баялаг нөөцтэй Венесуэл баян орон болж чадаагүй гол шалтгаан нь институцийн сул хөгжлөөс үүдэлтэй. Азийн загвар ба “институцийн онол”-оор эдийн засгаа удирдан чиглүүлж, өндөр амжилтад хүрсэн орны нэгж жишээ нь Өмнөд Солонгос.

Азийн бар болон хөгжсөн орнуудын онцлог:

1. Коммунист бус гэхдээ дангаар ноёрхох улс төрийн систем шударга ажилласан
2. Экспортод тулгуурласан эдийн засгийн бүтэцтэй.
3. Дотоодын ба гадаадын бодит аюул занал харьцангуй бага.

4. Онолд бус практик туршлагад илүү найдах хандлага давамгайлсан.

5. Маш их гутамшиг, доромжлол амссан нь үндэсний үзэл маш өндөр болоход нөлөөлсөн.

6. Азийн үнэт зүйлс болох ёс суртахууны хэм хэмжээ, шатлан захирагдах ёс, удирдагчийг хүлээн зөвшөөрөх үзэл гүнзгий төлөвшиж чадсан.

7. Эдийн засгийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд төрийн оролцоо гүнзгий байсан.

Зөвлөмж:

Бид дээрх загварыг сонговол юун түрүүн ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?

-Мэдээлэл технологийн эрин зуунд хамгийн сүүлийн үеийн мэдлэг боловсрол, шинжлэх ухааны ололтод тулгуурласан эдийн засгийн бүтэц бий болгох,

-Урт хугацааны хөрөнгө оруулалтыг дэмжих

-Орлогын хуваарилалтыг инноваци шингээсэн мэдлэг болон технологийн салбарт түлхүү өгөх,

-Макро түвшний бодлогоос микро түвшинд асуудлыг авчирч шийдэх,

-Үндэсний үйлдвэрлэлийг эргэлт буцалтгүйгээр дэмжих

-Авлига, хүнд суртлыг халах,

-Нийгмийн бүх салбарт ёс суртахууны хэм хэмжээг өндөрсгөх,

-Хөдөлмөрийн цагийг уртасгах,

-Эдийн засгийг улс төр, үзэл сурталтай хутгахгүй байх,

-Хүн бүхэнд эх орноо гэсэн үзлийг суулгах. ■



ҮЗЭЛ БОДОЛ

БОХИРДУУЛАГЧДЫГ МАГТАН ДУУЛАХАА БОЛИХ ЦАГ ИРСЭН



2013 оны дэлхийн байгаль орчны өдөр"-ийг Монгол Улс хүлээн авч тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Тогтохын Чулууны "RIO-20"-д зорилан илэрхийлсэн байр суурийг гаднын хэвлэл нийтэлснийг хүргэж байна.

Дэлхийн орнуудын хариуцлагатай хөгжлийг урамшуулан дэмжихийн тулд НҮБ-ийн Амьдралын төвшний индекст тогтвортой байдлыг тусгах шаардлагатай.

Энэ сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэлхийн орнуудыг хөгжлийн төвшингээр нь харуулсан жагсаалт /жилээр/ гаргажээ. Уг жагсаалтыг ямар улс тэргүүлж байгаа бол. Багцаалдаад хэлэхэд АНУ, Канад, Австрали зэрэг орнууд жагсаалтын эхний зургаад багтаж байгаа бол манай орон 110 дугаар байрт орсон байна.

НҮБ тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд ихээхэн хүчин чармайлт тавьж байгаа боловч ихэнх тохиолдолд Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь тогтвортой байдлыг үл ойшоодог. Үүнээс ч тааруухан зүйл бол уг индекс нь хэтэрхий их түлш хэрэглэдэг хөгжиж буй орнуудыг хөхиүлэн дэмжсэн хэвээр байгаад оршино. Цулгүй орон зайд нуугдаж буй энэхүү алдаа, дутагдлыг ил гаргаж, арилгах цаг одоо болсон.

ХХИ нь хорь гаруй жилийн туршид дэлхийн орнууд болон олон улсын байгууллагуудын шууд хэрэглэдэг жишиг үзүүлэлт болжээ. Үүний амжилт, нөлөөллийн үр дүн ихэнхдээ хэрэглэхэд хялбархан байдагтай нь холбоотой аж. ХХИ нь эрүүл мэнд, боловсрол, орлогын төвшинг ашиглан тухайн орны хөгжил болон амьдралын төвшнийг маш сайн нэгтгэж чаддагаараа онцлог. Гэвч энэ нь сүүлийн үед чухлаар тавигдах болсон нэг асуултад хариулж чадахгүй байна. Тухайн хөгжил хэр зэрэг хариуцлагатай байх бол. Дэлхийн хүн ам өнгөрсөн сард долоон тэрбумд хүрсэнтэй холбоотойгоор НҮБ-ын тогтвортой байдлын төлөө юу зориулж байгааг асуух үндэслэлтэй юм.

Одоогийн ХХИ-т хөгжлийн замнал нь байгаль орчин болоод хүн төрөлхтний цаашдын хөгжилд хэрхэн хор

хөнөөл учруулж, аюул заналхийлж буйг үл харгалзан өндөр хөгжилтэй болон газрын тосоор баялаг орнуудыг дээгүүр жагсаасан байгаа юм. Гэтэл байгалийн нөөц, баялаг хязгааргүй юм шиг ойлголт газар авч, хөгжлөөс үүдэн байгаль эхийн биологи, физик болон химийн үйл явцад гарч буй голлох өөрчлөлтүүдийг төдийлэн анхаарахгүй байна. Бид ямар нэг гайхамшиг болно гэсэн өөдрөг үзлээ тогтоон барьж чадаагүйн зэрэгцээ энэхүү том сорилтыг давж гарч чадах эсэхдээ хүртэл эргэлзэх болсон нь оролдоод үзэхийг ч хүсэхгүй хэмжээнд хүргэж, хаашаа ч үгүй болгожээ.

НҮБ 1992 онд Бразилийн нийслэл Рио де Жанейрод болсон Дэлхийн дээд хэмжээний анхны уулзалтаараа тогтвортой хөгжлийн гурван тулгуур багана болох эдийн засаг, нийгэм болон байгаль орчны хөгжлийг тодорхойлжээ. Дэлхий дахинд хүн төрөлхтөн дээрх гурван тулгуурын эхний хоёроор нь хосгүй ололт, амжилтад хүрч чадсан. Гэвч хялбарчлал (reductionism), задрал (fragmentation), хуваагдал (division), газар нутгийн эзэмшил (territoriality) зэргийн дүнд эдгээр гурван хэмжээсийг нэгэн зэрэг шийдвэрлэх тал дээр үр дүн муутай байв. ХХИ нь энэхүү тархай, бутархай арга барилын бэлгэ тэмдэг болж байна.

НҮБ 2012 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтаа Рио де Жанейрод хийхээр төлөвлөж буй бөгөөд үүнийг үлгэр жишээч удирдан явуулах ёстой. Ирэх жилээс ХХИ-ийг тооцдог арга барилаа өөрчлөх шаардлага тулгарч байна. Дахин шалгаж, шинээр боловсруулах индекст нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий ялгаруулах хэмжээг тусгаж өгснөөр энэ нь "Хүний тогтвортой хөгжлийн индекс" болж хувирах боломжтой.

Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий ялгаруулалтын хэмжээ нь хялбархан бөгөөд тоо хэмжээг нь ▶



▶ тодорхойлоход боломжтой үзүүлэлт юм. НҮБ-аас энэ сард гаргасан тайланд эдгээрийн зарим чухал шинжилгээг ХХИ-т тусгасан гэдгээ мэдэгдээд байна. Нүүрсхүчлийн хий ялгаруулалт нь хүмүүсийн ашиг, орлоготой эерэг бөгөөд хүчтэй уялдаа холбоотой боловч ХХИ-тэй харьцангуй бага хамааралтай. Харин эрүүл мэнд, боловсролтой ямар ч холбоогүй. Ерөнхийдөө аливаа орны ХХИ-ийн үзүүлэлт хурдацтай сайжрахын хэрээр нүүрсхүчлийн давхар ислийн хий ялгаруулалтын хэмжээ улам нэмэгддэг. Асуудлын гол нь ХХИ-ийн үзүүлэлт сайжрахад дэлхийн дулаарал нэмэгдэж, байгаль орчинд хор хөнөөл учруулдаг оршиж байна. Гэхдээ байгаль орчинд үзүүлэх эдгээр хор хөнөөл нь зөвхөн эдийн засгийн өсөлттэй холбоотой болохоос биш ХХИ-ийн өргөн хүрээний өсөлттэй ямар ч холбоогүй бөгөөд эдгээрийн хоорондох харилцаа ч тогтсон хэв маягтай биш юм. Зарим орнууд ХХИ болон байгаль орчны тогтвортой хөгжлийн аль алианаар нь тэргүүлсэн үзүүлэлттэй байна.

Тэгвэл нүүрсхүчлийн хий ялгаруулалтыг ХХИ-т тусгаснаар хэрхэн нөлөөлөх бол. Үүнийг олж мэдэхийн тулд миний бие НҮБ-аас гаргасан аргачлалыг ашиглан индексийг дахин тооцож үзлээ. Гэхдээ нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын хэмжээг голлон авч үзсэн болно. Хүний тогтвортой хөгжлийн индекс /ХТХИ/-ээр сонирхолтой үр дүн гаргасан юм.

ХХИ-ийн дагуу Австрали, АНУ, Канад зэрэг эхний аравт цойлж явсан орнууд ХТХИ-ийн дагуу огцом хойшоо ухарсан. Австрали хоёрдугаар байрт байсан бол 26, АНУ дөрөвдүгээр байраас 28, Канад зургадугаар байраас 24 рүү тус тус ухарсан үзүүлэлттэй гарсан.

Энэхүү тогтвортой байдлын индексийн дагуу хэм хэмжээг нь тааруулахыг (moderation) эрхэмлэдэг орнууд сайн үзүүлэлттэй байна. Тухайлбал, Норвеги тэргүүлэх байр сууриа алдаагүй бол Швед аравдугаар байраас хоёрт, Швейцарь арваннэгдүгээр байраас гуравт дээшлэн эрэмблэгдсэн.

Дэлхийн орнуудын хариуцлагатай хөгжлийг урамшуулан дэмжихийн тулд НҮБ-ын Амьдралын төвшний индекс тогтвортой байдлыг тусгах шаардлагатай

Скандиновын орнуудад очиж үзсэн хэн боловч хэм хэмжээг тааруулснаар (moderation) амжиргааны дээд түвшин заавал буурах албагүй гэдгийг ойлгох болно. ХТХИ-ийн дагуу тэргүүлэгч орнуудын тоонд Азийн нэгэн орон анх удаа орж ирсэн. Хонконг 13 дугаар байрт байсан бол дөрөвт гарч ирэв. Харин Япон, БНСУ зэрэг орон эхний аравт багтаагүй ч ганц, хоёрхон байраар доошилсон үзүүлэлттэй байна.

Ялангуяа нефть үйлдвэрлэгч болон нефтийг ихээр ашигладаг орнууд хамгийн ихээр доошилсон үзүүлэлттэй байгаа юм. Арабын Нэгдсэн Эмират улс, Бруней Дарассалам, Катар, Люксембург, Бахрейн зэрэг орон “Хүний хөгжлийн өндөр төвшин”-тэй орнуудын дөрөвний нэгт ч багтахгүй болсон.

ХТХИ-ийн дагуу Монгол Улс бага зэрэг урагшилсан үзүүлэлттэй байна. Манай орон дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засгийн нэг болох төлөвтэй байгаа ч одоогийн ХХИ нь цаашид тогтвортой хөгжихөд нь ямар ч түлхэц болж чадахгүй байна. Улаанбаатар хот агаарын хамгийн их бохирдолтой хотуудын эгнээнд аль хэдийнэ орсон. Манай оронд усны болон ойн нөөц, малын тэжээл улам л хомсдох болсон. Монгол Улс өнөөдөр байгаль орчин, нийгэм, эдийн засаг, улс төр болон соёлын хөгжлийнхөө эргэлтийн цэг дээр зогсож байна. Байгаль орчин болон соёлын тогтолцоогоо хамгаалах, ногоон технологийг нэвтрүүлэхэд бидэнд олон улсын хамтын оролцоо зайлшгүй хэрэгтэй.

Энэ нь хүний мөн чанарын нэгээхэн хэсэг бүх төвшинд тэмцэлдэх гэж буй мэт санагдах боловч үүнийг хязгаарлах боломжтой. ХХИ-ийн материаллаг хөрөнгийн цаадах хөгжлийн зорилтыг өөрчилсөн. Ингэснээр санал болгож буй ХТХИ нэг алхам урагшилж, хөгжлийн загварыг өөрчлөх боломжтой болох юм. Иймэрхүү өөрчлөлт бидэнд үнэхээр хэрэгтэй байна. Хэрэв НҮБ энэ маягаар Монгол гэх мэт улсыг Америк маягийн амьдралын хэв маягтай болгохоор дэмжсээр байх юм бол бид ноцтой асуудалд орох болно. ■

ТОМИЛОЛТ

“АЛТАЙН ХҮДЭР”-ИЙН “СУПЕР” ТӨЛӨВЛӨГӨӨ

Б.ТОГТОХ

Баруун бүсэд төмрийн хүдрийн гурван орд бий. Түүний нэг нь Говь-Алтай аймгийн Цээл сумын нутаг дахь Таян нуурын орд. Ордын нийт нөөц 160 сая тонн гэх боловч нарийвчилсан судалгааны ажил одоо ч үргэлжилсээр байна. Өөрөөр хэлбэл, дээрх хэмжээ хэр баталгаатай, нөөц хэрхэн хувьсахыг өнөөдөр таах аргагүй юм.

Манай улс өнгөрсөн оны байдлаар 726.5 сая тонн төмрийн хүдрийн нөөцтэй гэсэн тун нарийн тоо гарсан. Анх удаа төмрийн хүдрийн албан нөөцөө хувилж гаргасан нь энэ. Өмнө нь ойролцоогоор баримжаалдаг байсан бол одоо 700 гаруй сая тонн гэсэн тодорхой багцаатай боллоо. Энэ нь дэлхийн нийт нөөцийн 0.6 хувийг эзэлж байна.

Дэлхийн төмрийн хүдрийн нийт нөөцийн 17 хувь нь Ази тивд ногддог. Тэгвэл Монгол Улс Ази тивдээ гангийн зах зээлд ганцаараа тоглолт хийх, тус зах зээлийн түүхий эдийн үнийг тодорхойлогч байх боломжтойг Энэтхэгийн ган үйлдвэрлэлийн удирдах газрын төлөөлөгч Хридаяа Мохан хагас жилийн өмнө Улаанбаатарт ирэхдээ хэлж байлаа. Түүний хэлсэн мөрөөдлийн гэмээр “супер” төлөвлөгөө Алтайн өвөр говьд биелэлээ олоход ойртжээ.

Сүүлийн 50 жилд гангийн хэрэгцээ 50 дахин өссөн байдаг. Энэхүү статистик үзүүлэлт төмрийн хүдэр хэр эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болохыг нотолж байгаа юм. Тиймээс төмрийн хүдэр олборлогч 10 компани “Монгол ган нэгдэл” хувьцаат компанийг байгуулсан хэрэг. Тус нэгдэлд “Алтайн хүдэр” компани элссэн бөгөөд хамтран санаачилсан “гол төлөөлөгч” нь юм байна. Алтайн цаад говьд хариуцлагатай уул уурхай сайн соёлыг төлөвшүүлж, орон нутгийн хөгжилд гэгээ болж яваа тус айлаар буугаад мордлоо.

Айлын “эзэн” сайхан ааштай, ажил амьдрал ч урагштай явна, тэнд. “Алтайн хүдэр” үндэсний гэх тодотголтой цөөхөн уул уурхайн компанийн нэг нь. Өөрөөр хэлбэл, ашиг нь гаднын аль нэг орныг зорих бус дотоодын эдийн засагт шингэдэг гэсэн үг. Мөн төмрийн хүдрийг баяжуулах үйлдвэрлэлийн дамжлагыг цогцоор нь ашигладаг онцлогтой. “Таян нуур”-ын уурхай баруун бүсэд том ажил олгогч болсныг гэрчлэх мэт шинэ суурин Бага Таянгийн өвөр хоолойд төвхнөжээ.

Тус уурхайн дарга Д.Дандар “Манай төмрийн хүдрийн биет өргөн нь 65 метр. Урт нь 1200 метр. Энэ нь маш ховор»



▶ тогтоц бөгөөд олборлолт явуулах боломжтой. Ордын дундаж агуулга 39 хувь. Хүдрийн биет 85 градус босоо байрлалтай” хэмээн тайлбарлахын зэрэгцээ бидэнд хөтөч хийлээ.

Уурхай тэгш тоотой саруудад Бургастайн боомтоор төмрийн баяжмалаа экспортод гаргах бөгөөд 15-20 жил үйл ажиллагаа явуулах боломжтой аж. Нэг тонн төмрийн хүдрийн баяжмалаа 60 ам.доллараар урд хөршид зардаг гэдгээ Д.Дандар дарга нуусангүй. Компанийн зүгээс нойтон баяжуулалтын аргыг нэвтрүүлэх талаар судалгаа шинжилгээ эхлүүлсэн гэдгээ тэрбээр дуулгасан. Нойтон баяжуулах үйлдвэр ашиглалтад орсон тохиолдолд нийт

ашигласан усныхаа 98 хувийг дахин ашиглах технологийг судалж байгаа гэлээ. Уурхайн олборлолт явуулж буй газар нутаг нь Цээл сумын нийт нутаг дэвсгэрийн 0.1 хувьд ч хүрэхгүй аж. Гэсэн ч хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхээр зорьж яваа нь олзуурхах жишээ байлаа.

Төмөрлөгийн үйлдвэрлэлд бий болсон нэг ажлын байр араасаа таван ажлын байр дагуулдаг гэнэ. Түүний жишгээр тус компанийн Таян нуурын уурхайд 1500 гаруй монгол хүн ажиллаж байна. Нэг дор 1500 хүн байрлахад саад бэрхшээл, хүндрэл мундахгүй их. Тэгвэл эдгээр асуудлыг инженерийн аргаар төгс шийджээ. Уурхайд ажиллаж буй 1500 гаруй хүний 400 орчим нь орон ▶



▶ нутгийнх гэхээр талархууштай санагдсныг нуух юун.

Говь-Алтай аймагт сүүлийн гурван жилийн хугацаанд ажилгүйдэл эрс буурч, иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн гэсэн тойм судалгаа гарчээ. Мөн аймгийн төсөв ашигтай гарч, татварын орлого жил бүр өсөн нэмэгдсэн байна. Тус судалгааны дүгнэлтээс үзэхэд Таян нуурын уурхайг тойрсон сумдын хөгжилд дорвитой өөрчлөлт гарч байгааг онцлон тэмдэглэжээ.

Цээл сумын Бүрэнжаргал багийн Засаг дарга Б.Ганзориг “Манай суманд ажилгүй хүн байхгүй. Уурхай дагаад иргэдийн аж амьдрал өнгө засч, орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг болж байна. Үүнээс гадна иргэдийн шилжих хөдөлгөөн зогссон. Ядуурал, архидалт, ажилгүйдэл гэх “хэцүү гурав” холдсон” гэв.

Дэлхийн хэмжээнд тэргүүлэх таван байгалийн баялагт төмрийн хүдэр багтдаг. Тиймээс аль ч орны эдийн засгийн эрэлттэй бүтээгдэхүүн байх боломжтой төмрийн хүдрийн тун нарийн боловсруулалт, шат дамжлагыг Таян нуурын уурхайд үзлээ. Бидний олонх нь төмрийн хүдрээ түүхийгээр зөөлөө гэж нийтэд нь харлуулах гээд байдаг сул тал бий. Тэгвэл олон харын дунд цагаан байдаг болохыг сануулсан үйлдвэрлэл Дархан, Сэлэнгэд бус холхи Алтайн тэсгэл алдам халуун говьд ашиглалтад оржээ.

Хуурай аргаар баяжуулах үйлдвэр жилийн ойтойгоо золгож байгаа аж. Бид жилийн дараа очиж үзсэн нь энэ. Монголд “Болд Төмөр Ерөө гол” компанийн болхи аргыг эс тооцвол ганцхан хувь гэж хэлж болох соронзон аргаар баяжуулах үйлдвэр нэг ээлжиндээ 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаатай газар дээр нь танилцлаа.

Тус баяжуулах үйлдвэрийн ерөнхий инженер С.Баярсайхан “Нэг цагт 600-650 тонн хүдэр боловсруулж, 200-300 тонн баяжмал үйлдвэрлэдэг. Он гарсаар эхний дөрвөн сарын байдлаар 400 мянган тонн хүдэр баяжуулаад байна. Үйлдвэр гурван шатны бутлалтай бөгөөд эцсийн шатанд хүдэр соронзон баяжуулалтаар орж, төмрийн агуулга 60 хүртэлх хувиар арвиждаг” гэж С.Баярсайхан ярилаа.

Соронзон аргаар баяжуулсан төмрийн хүдрийн баяжмал нь арвайн гурилтай нэн төстэй. Ширхэг нь тун нарийн бөгөөд нунтаг гурил лугаа адил. Говь-Алтай аймгийн брэнд бүтээгдэхүүний нэг нь халтар арвайн гурил. Тэгвэл баруун бүсийн уул уурхайн брэнд бүтээгдэхүүнийг нэрлэ гэвэл “Алтайн хүдэр”-ийн баяжуулсан төмрийн хүдэр “нэр дэвших”

нь ээ.

Үйлдвэрийн Технологийн инженер А.Тогтохын хэлснээр баяжуулах үйлдвэрт тоос сорогчтой адил зарчмаар ажиллах “аварга” төхөөрөмж үйлдвэрлэлийн явцад тархах тоос, шороог өөрийн биедээ “юүлдэг” юм байна. Түжигнэх чимээ, нүжигнэх үйлдвэрлэлийн дуунд дасч мэдэх нь. Нүсэр үйлдвэрийн сүр бараанд дарагдсан нүцгэн толгод аниргүйхэн.

“Соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн давуу тал нь төмрийн хүдэрт нэмүү өртөг шингээж, бүтээгдэхүүний агуулгын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлдэг. Тухайлбал, төмрийн 37 хувийн агуулгатай хүдэр баяжуулалтаас баяжмал болж гарахдаа 62 хувийн агуулгатай гарч, хаягдал нь 20 хувийн агуулгатай үлддэг. Цаашдаа нойтон баяжуулалтын төсөл хэрэгжих үед хаягдал хүдрээ дахин баяжуулна” хэмээн С.Баярсайхан тайлбарлалаа. Хэрэв нойтон баяжуулах үйлдвэр ашиглалтад орлоо гэж үзэхэд хаягдалын хэмжээ 10 хүртэлх хувиар багасах аж.

Говьд зам тавих, тэр тусмаа Алаг нуурын говьд хатуу хучилттай хүнд даацын зам босгох нь хэр баргийн хүний хийх ажил биш болохыг Говь-Алтайхан мэднэ. Зөвхөн Алтайнхан бус Өмнөговьд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компанийнхан гадарлана. Өөрөөр хэлбэл, тэд зовлон нэгтэй улс. Гэсэн ч саад бэрхшээл, салхи шуурга, халуун нар, байгалийн эрс тэс нөхцөлд үл түүртэн “Алтайн хүдэр” компани зам барилгын ажилдаа ханцуй шамлан оржээ.

“Алтайн хүдэр” компанийн Замын хэлтсийн захирал Ч.Идэр “Манай авто замын ажил 2009 оноос эхэлсэн. Эхний ээлжинд тээвэрлэлтийн асуудлаа шийдэх үүднээс сайжруулсан зам барих ажлыг богино хугацаанд амжилттай гүйцэтгэсэн. Говийн хөрс эмзэг, салаа зам гарах магадлал өндөр учраас хатуу хучилттай, хүнд даацын зам барьж байна. Өнөөдрийн байдлаар нийт тавих 168 км замынхаа 80 км-т нь суурь бүтцийг барилаа. Нийтдээ замын ажилд компанийн зүгээс 28 тэрбум төгрөг зарцуулаад байна” гэлээ.

Таян нуурын ордоос Бургастайн хилийн боомт хүртэлх 168 км хүнд даацын цемент бетон хучилттай авто зам Монголд хэдхэн бий. Үүний нэг нь “Алтайн хүдэр”-ийн бус алтайчуудын хөгжлийн зам болох юм. Нийслэлд “од” болж, олны хараанд өртөөд байсан “Алтайн хүдэр”-ийн бодит байдал газар дээрээ нэг ийм. Тэндээс хотод түгэж амжаагүй сонин сайхныг тантай хуваалцлаа. ■



МОНГОЛЫН АРЬС ШИРЭН
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН
ХОЛБОО



МОНГОЛЫН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО



MISHEEL GROUP

EXPO - FURNITURE - BUSINESS PARK



МОНГОЛ НААДАМ МОНГОЛ БРЭНД 2013

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА

Ардын Хувьсгалын 92 жилийн ойг угтан
Монгол улсаа сурталчилж Монгол брэндээ дэмжицгээе !

*НООС НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН
МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХУВЦАС
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН
АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН*

*ТАР УРЛАЛ, БЭЛЭГ ДУРСТАЛ
АЯЛАЛ ЖУУЧЛАЛ, АМРАЛТ СУВИЛАЛ
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН
МОНГОЛ ОНЬСОН ТОГЛООМ*

ҮЗЭСГЭЛЭНГИЙН БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

БАЙГУУЛЛАГА, БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ХОЛБООДЫГ ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.

Утас: 88077064, 95950811, 99071751

2013.6.29-7.2 МИШЭЭЛ ЭКСПОД



ОЮУТОЛГОЙН БУЛАН

СЭТГЭЛ ХАНГАЛУУН АМЬДРАЛ



Б.АЛТАЙ

Дэлхийн банкнаас гаргасан Монгол Улсын эдийн засгийн тоймд өгүүлснээр манай улсын эдийн засаг энэ онд 13 хүртэлх хувиар өсөх эсэх нь “Оюутолгой” төслөөс шууд хамаарна.

Дэлхийн улс орнууд санхүүгийн хямралыг гэтэлж, Азийн “нуруу тэнийлээ”. Хөгжиж буй орны эдийн засаг эрчимтэй өсч, “буурал тив” амсхийв. Зэсийн үнэ энэ онд байгаагүй тааруухан амжилт үзүүлж байгаа ч найдвар алдарсангүй. Алтны ханш

сэм “рекорд” тогтоож, ам.долларын ханш аажмаар чангарсаар АНУ эргэн ирж байна.

Дэлхийг бүрхээд байсан хямралын сүүдэр алгуур үргэж байгааг нотолсон сайн мэдээ түгэх боллоо. Манай улсын эдийн засагт нөлөөлөх гадаад “шок” ийм. Тэгвэл дотоод эдийн засгийн “донсолгоон” улс төрийн бодлогоос ихээхэн хамаардаг нь нууц биш ээ. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогын ул мөр эдийн засагт “гэнэтийн бэлэг” ч болдог.

Хэдий эдийн засгийн өсөлтөөрөө манайх дэлхийд толгой цохиж байгаа ч бодит цалингийн системд тэнгэр, газар шиг ялгаа үүссэн. Энэ нь уул уурхайн эдийн засгийн давуу болоод сул тал юм. Учир нь Оюутолгой, Тавантолгойн зүг хошуурсан “их нүүдэл” нь өндөр цалинтай холбоотой. Гэсэн ч цалин дагасан “нүүдэл” эргээд эдийн засагт хөрөнгө оруулалт хийж байна.

“Хоёр толгой”-н төсөөлөл нийт монголчуудын амьдралд “зүүд” гэмээр боломжийг олгосон. Нэг нь хувьцаа тарааж, нөгөө нь дэлхийн хэмжээний цалинг Монголдоо авах ажлын санал тавьсан. Түүнээс бодитой биелсэн “Оюутолгой”-н цалин. Ром хотыг нэг өдөр бариагүй. Үүнтэй адил Оюутолгойн бүтээн байгуулалт гурван жил дамнасан байдаг. Тус төслийн үр шимийг хүртэж яваа олны олон нь монголчууд. Өнгөрсөн хугацаанд “Оюутолгой” компанитай ажил, амьдралаа холбосон олон хүний амьдралд том эргэлт, эрс шинэчлэл гарч байгааг бид мэднэ. Тэдний амьжиргааны түвшин дээшилж, сэтгэл хангалуун амьдрах баталгаа нь “Оюутолгой” болсон. Монгол Улсын цалингийн системд байхгүй “өндөр тоо”-г ч тэд амласан. Товчхондоо улсын эдийн засгийн өөрийнх нь хүчин чадлаас хэт давсан цалинг “Оюутолгой” олгосоор. Монголчууд хамгийн бага цалинг авч байна хэмээн шуурах ч дэлхийн хэмжээний цалинг “явдал суудал”-гүй төрөлх нутагтаа хүртэж байна. Баялгийн шим сэтгэл хангалуун амьдрах боломжийг монголчуудад нээхийн сацуу эдийн засагт дэм болсоор.

“Оюутолгой” компанийн ажилтан Ц.Мөнхчулуун “Би орон сууцны хөнгөлөлтэй зээлд хамрагдсан. Тохьтой байр сууц хүний хамгийн чухал анхан шатны хэрэгцээ байдаг. Харин орон сууцнаас цааших хэрэгцээг хүмүүс өөрсдөө сонгож бүтээдэг бол би тэр боломжоо олон хүмүүст хэрэг болох тэр л зүйлд зориулна. Надад амьдрах байр хэрэгтэй байсан. Энэ хэрэгцээгээ хангаж чадсандаа баяртай байдаг” хэмээн сэтгэгдлээ хуваалцсан юм.

“Компанийн зүгээс Голомт, ХААН, Худалдаа хөгжлийн банкуудтай гэрээ байгуулан, ажилтнуудаа орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулж байгаа. Зээлийн хүүгийн хувьд хөнгөлөлттэй нөхцөл олгохын зэрэгцээ байрны урьдчилгаа төлбөр болон банкны үйлчилгээний шимтгэлүүдэд хөнгөлөлт үзүүлдэг” хэмээн компанийн Хүний нөөцийн ахлах ажилтан П.Март онцлов.

Өнөөдөр барилгын салбарын гол худалдан авагч нь уул уурхайн салбарынхан болж байна. Тэд зөвхөн иргэдэд цалин олгоод зогсохгүй орон сууцны зах зээлийг дэмжиж байгаа юм. “Оюутолгой” компани өнгөрсөн онд 1400 орчим ажлын байр шинээр бий болгожээ. Тус компанийн Хүний нөөцийн бүрдүүлэлтийн ахлах мэргэжилтэн Э.Цэлмэг “Компанийн нийт ажилчдын 90 гаруй хувь нь монголчууд. Бид ажилчдадаа Монголын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс олгодог” хэмээн ярилцлага өгчээ.

“Оюутолгой-Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ” судалгаанд тэмдэглэсэнээр 2020 он гэхэд Монгол Улсын дундаж бодит цалин 30 хувиар өсөх бөгөөд энэ тоо 2023 онд 35 хувь болж оргилдоо хүрэх аж. Оюутолгойн ашиглалт нь хөдөлмөрийн эрэлтийг нэмэгдүүлэх бөгөөд энэ нь бодит цалинг өсгөх үндсэн хөшүүрэг болно гэж судалгаанд өгүүлжээ. ■